



УЛГА

Аудитыг гүйцэтгэсэн:

Гүйцэтгэлийн аудитын
газрын дарга бөгөөд
тэргүүлэх аудитор
М.Давааням

Аудитын менежер:
Л.Эрдэнэчулуун

Ахлах аудитор:
Б.Саруул

Аудиторууд:
Б.Лхагвацэрэн
Б.Хаш-Эрдэнэ
Б.Булган
Б.Анхбаатар
И.Туяадарь
Х.Энх-Амгалан
Ц.Цолмон
М.Доржмаа
Ж.Ганчимэг
Д.Даваа-Эрдэнэ

Гэрээт ажилтан
Б.Алтангэрэл

УАГ-ын Гүйцэтгэлийн
аудитын болон 12
аймаг, нийслэл дэх
Төрийн аудитын газар
оролцов.

2018 оны 6 дугаар сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
263755, 261675, 261805
дугаарын утсаар
харилцана уу.

Уг тайланг УАГ-ын
Веб сайт-аас үзнэ үү.
www.audit.mn

Хаяг:

Улаанбаатар 15160,
Бага тойруу 6, Засгийн
газрын ГҮ байр
Монгол Улс

Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	4
Аудитад ашигласан шалгуур	4
Товчилсон үгийн тайлбар	5
Үндсэн мэдээлэл	7

Бүлэг 1. Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдахгүй байна

▪ Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тодорхой бодлого, хэрэгжих дарааллаар төлөвлөсөн гэх үндэслэл бага байна	12
▪ Төсвийн тухай хуульд төлөвлөлтийн алдаатай, хуулийн шаардлага, бэлтгэл хангагдаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасаар байна	14

Бүлэг 2. Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна

▪ Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, тогтоомж, журмын холбогдох заалтыг бүрэн мөрдөхгүй байна	19
▪ Барилгын салбарт мөрдөгдөх норм стандарт, дүрэм журмын шинэчлэлийг шуурхай зохион байгуулах шаардлагатай байна	22
▪ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт 80.7 хувийн гүйцэтгэлтэй байна	23
▪ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих барилга, байгууламжийг нормативт хугацаанд ашиглалтад оруулдаг болгох шаардлагатай байна	23
▪ Барилга угсралтын ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн ажлын хариуцлага сул байгаагаас чанар муутай барилгууд баригдсаар байна	24
▪ Төсвийн ерөнхийлөн захирагчид гэрээний хэрэгжилтэд тогтмол, чанартай хяналт тавихгүй, эрх мэдлээ хэтрүүлэн төсвийн хэмнэлтийг зарцуулсан байна	25
▪ Ажлын гүйцэтгэлийг бодитой хянаагүйгээс хийгээгүй ажлын гүйцэтгэлд санхүүжилт олгосон байна	28
▪ Гүйцэтгэгч ажлаа хугацаанд нь гүйцэтгээгүйгээс батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглахын тулд тухайн жилийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулжээ	29
▪ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагч нарт хяналт бүрэн тавьж чадахгүй байгаагаас санхүүжилтийн явцад хууль, журам зөрчигдөж байна	30
▪ Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна	33

Бүлэг 3. Хөрөнгө оруулалтын үр дүнг тооцох аргачлал боловсруулж, хэрэгжилт, гүйцэтгэлд тавих дотоод аудитын болон хөндлөнгийн хяналтын тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай байна

▪ Хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна	34
▪ Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг төлөвлөх, тооцох эрх зүйн орчинг бүрдүүлээгүй байна	35
▪ Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт хангалтгүй байсан нь хөрөнгө оруулалтын үр дүнд сөргөөр нөлөөлж байна	36
▪ Зарим салбарт оруулсан хөрөнгө оруулалт үр өгөөжөө өгч байна	37

Тайлангийн төсөлд ирүүлсэн санал:	39
Саналд өгсөн тайлбар:	41
Аудитын дүгнэлт:	42
Аудитын зөвлөмж:	44
Монгол Улсын Ерөнхий аудиторовын тайлан баталгаажуулсан тушаал:	46



Хавсралт 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн өртөг нэмэгдсэн төсөл, арга хэмжээний судалгаа	50
Хавсралт 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний судалгаа	52
Хавсралт 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хэрэгжилт дутуу төсөл, арга хэмжээний судалгаа	54
Хавсралт 4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлсэн бодит ажлын гүйцэтгэлээс илүү санхүүжилт авсан аж ахуйн нэгжийн судалгаа	55
Хавсралт 5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2017 оны санхүүжилтийн гүйцэтгэл	56



**Аудит хийх
үндэслэл:**

Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалаар батлагдсан УАГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон УАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2017 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын өгөөжийг бодитой тооцож, үнэлсэн эсэх.

Хамрах хүрээ:

Аудитыг Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ болон 3 дугаар хавсралтад батлагдсан концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжсэн эргэн төлөлт нь 2017 онд хийгдсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг Төсвийн ерөнхийлөн захирагчид, түүний харьяа байгууллагууд, Сангийн яам, ТӨБЗГ, Барилгын хөгжлийн төв, аймаг, нийслэлийн хяналтын чиг үүрэг, гүйцэтгэлийг хариуцагч эрх бүхий НХОГ, ГХБХБГ-ууд, зарим ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийг хамруулан гүйцэтгэв.

Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагууд аудит хийлээ.

Аудитын арга зүй:

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, АДБОУС 300, 3000-д нийцүүлэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журмын дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, мэдээ судалгааг цуглуулж, ажлын баримт материалд хавсаргав.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэхэд мөрдөгдөж буй хууль, эрх зүйн орчинг судлах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, судалгаа, тайлан, тодруулга зэрэг баримт, мэдээлэлд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх, зарим барилга, байгууламж холбогдох стандарт, норм, дүрмийн дагуу баригдаж байгаа эсэх талаар хөндлөнгийн мэргэжлийн шинжээчидтэй хамтран ажиллав.

**Аудитад
ашигласан
шалгуур:**

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 2, 3 дугаар хавсралт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт,
- Төсвийн тухай хуулийн 6, 10, 11, 12, 13, 27, 28, 29 дүгээр зүйл,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7, 8, 9 дүгээр зүйл,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль,
- Барилгын тухай хуулийн 7 дугаар зүйл
- Иргэний хуулийн 243-261, 343-358 дугаар зүйл,
- Концессын тухай хууль,
- Авто замын тухай хуулийн 4, 5, 13, 14, 15, 16, 18, 19, 20 дугаар зүйл,
- Эрчим хүчний тухай хуулийн 9, 20, 25 дугаар зүйл,
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан журам,
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд.



ИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:

АХУ	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АХБ	Азийн Хөгжлийн банк
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНБД	Барилгын норм ба дүрэм
БСПУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
БСПУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БХАҮН	Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХС	Батлан хамгаалахын сайд
БХТ	Барилгын хөгжлийн төв
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГХС	Гадаад харилцааны сайд
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ЗТБХБС	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд /хуучин нэрээр/
МСҮТ	Мэргэжлийн, сургалт үйлдвэрлэлийн төв
МУЕС	Монгол Улсын Ерөнхий сайд
МУШС	Монгол Улсын Шадар сайд
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТХМ	Төсвийн хүрээний мэдэгдэл
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын Их Хурал
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХШҮДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХУД	Хан-Уул дүүрэг
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭХС	Эрчим хүчний сайд



ГТТИЙН ЖАГСААЛТ:

№	Нэр	Хуудас
1	Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалт /тэрбум төгрөг/	8
2	Улсын төсвийн хөрөнгө оруулалт салбарын ангиллаар /тэрбум төгрөг/	9
3	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр /тэрбум төгрөг, хувь/	10
4	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон барилга, байгууламж /хүчин чадал/	11
5	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад орсон өөрчлөлт /тоо, тэрбум төгрөг/	13
6	Хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний судалгаа /ТЕЗ, тоо, сая төгрөг/	23
7	Хөрөнгө оруулалтын хэрэгжиж буй ТАХ-ний үргэлжилж буй хугацаа /тоо, жил, хувь/	24
8	Аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээний судалгаа /тоо, хувь, сая төгрөг/	37

Дүрслэлийн жагсаалт:

№	Нэр	Хуудас
1	Хөрөнгийн зардлын ДНБ-д эзлэх хувь /тэрбум төгрөг, хувь/	8
2	Төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын төсөв, төсөл, арга хэмжээний жагсаалтад оруулсан нэмэлт, өөрчлөлтийн судалгаа /тэрбум төгрөг, тоо/	9
3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэлийн судалгаа /тэрбум төгрөг, хувь/	10
4	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан хэлбэр /тоо/	19
5	ТЕЗ-дын үнэлгээний хороо байгуулагдсан хугацаа /сар, тоо/	19
6	Худалдан авах ажиллагааны үр дүнгээр гэрээ байгуулах эрх олгосон хугацаа /сар, тоо/	20
7	Хөрөнгө оруулалтын батлагдсан санхүүжилт, олголтыг харьцуулсан байдал /сая төгрөг, сар/	29
8	Хөрөнгө оруулалтын төлөвлөсөн үр дүнг гүйцэтгэлтэй харьцуулсан байдал /тоо/	34
9	Монгол Улсын сүүлийн 5 жилийн авлигын түвшин	36
10	2017 онд ашиглалтад орсон сургуульд хамрагдагсдын судалгаа /суралцагсдын тоо/	38



Үндсэн мэдээлэл

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8¹-д заасны дагуу Засгийн газрын 2012 оны 223 дугаар тогтоолоор “Монгол Улсын 2013-2017 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг баталсан байна.

Уг хөтөлбөрт заасан төслүүдийг хэрэгжүүлэх хөрөнгийн болон урсгал зардлын санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсвийн төлөвлөлт, төсвийн тодотголд тусгаж байх, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг тооцоолох шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах замаар хөгжлийн төлөвлөлтөд нийцүүлэх, хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдуулах улмаар төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хэрэгжүүлэх төслүүдэд төсвөөс гаргах нийт хөрөнгийн зардлын хязгаарыг олон улсын жишгийг баримтлан оновчтой тогтоохыг Сангийн сайдад даалгасан байна.

Мөн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон үндэсний хөтөлбөрт тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй уялдуулан нарийвчлан төлөвлөсөн баримт бичиг” гэж хуульчилсан².

ЗГХЭГ-ын дарга, Сангийн сайдын 2017 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 158/276 тоот хамтарсан тушаалаар Сангийн яам болон Үндэсний хөгжлийн газар Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсэг байгуулжээ.

Дээрх ажлын хэсэг нь Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 1711 дугаар тэмдэглэлээр салбар хариуцсан Төсвийн ерөнхийлөн захирагч нарт “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн төслийг холбогдох төсөл, арга хэмжээний саналын хамт 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний хөгжлийн газарт хүлээн авахаар шийдвэрлэсэн боловч аудитад хамрагдсан хугацаанд хэрэгжээгүй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэлд хөрөнгийн зардлын хэмжээг 1,813.5 тэрбум төгрөг, ДНБ-д эзлэх хэмжээг 6.6 хувь байхаар баталсан байна.


Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар хөрөнгийн зардлын хэмжээг 1,579.8 тэрбум төгрөг, ДНБ-д эзлэх хэмжээг 6.1 хувь болгосон ч 2017 оны 10 дугаар сарын 26-нд оруулсан хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хөрөнгийн зардлын хэмжээг 1,813.5 тэрбум төгрөг, ДНБ-д эзлэх хэмжээг 6.6 хувь байхаар буцаан нэмэгдүүлсэн байна.

¹ Төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийн хүрээнд Засгийн газар улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг дөрвөн жилд нэг удаа баталж, жил бүр тодотгоно.

² Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 4.1.9



Л 1. Хөрөнгийн зардлын ДНБ-д эзлэх хувь /тэрбум төгрөг, хувь/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Сангийн яам

Монгол Улсын Засгийн газар 2017 оны Төсвийн тухай хуулийн төслийн саналыг боловсруулахдаа УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолоор өгсөн чиглэлийг удирдлага болгон шинээр барилга, байгууламж эхлүүлэхгүй байх, өмнөх оноос шилжин ирсэн төслүүдийн санхүүжилтийг гүйцэтгэлтэй нь уялдуулан тусгах, өмнөх онуудад эхэлсэн боловч орхигдсон ажлуудыг дуусгах, зайлшгүй шаардлагатай боловсрол, эрүүл мэндийн салбарын их засвар, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг түлхүү тусгах гэсэн зарчмыг баримталсан байна.

Хүснэгт 1. Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалт /тэрбум төгрөг/

Хөрөнгө оруулалтын ангилал	2017 оны ТХМ	2017 он байгуул - лагын санал	Засгийн газарт танилцуулсан төсөл	УИХ-д өргөн барьсан төсөл	УИХ-аар батлагдсан		
					Хууль /2016.11.10/	Тодотгол 1 /2017.04.14/	Тодотгол 2 /2017.10.26/
Улсын төсвийн	273.5	3,105.3	273.5	259.1	250.6	492.9	602.1
Концессын эргэн төлөлт	140.4	329.7	140.4	115.4	71.5	70.9	177.7
Хөгжлийн банкны санхүүжилтээр төсвөөс эргэн төлөгдөх	55.5	336.9	236.9	172.8	172.8	-	-
НИЙТ	469.4	3,771.9	650.8	547.3	494.9	563.8	779.8


Эх сурвалж: Сангийн яам

Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний тоог 73-аар буюу 23.2 хувиар, санхүүжүүлэх дүнг 284.9 тэрбум төгрөг буюу 57.6 хувиар тус тус нэмэгдүүлсэн байна.

Монгол Улсын 2012-2018 оны Төсвийн тухай хуульд оруулсан өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр авч үзвэл, жил бүрийн төсөвт 1-2 удаагийн тодотгол хийсэн бөгөөд 2013-2015 онуудад бууруулж байсан бол 2016-2017 онд төсвийн орлогын өсөлттэй уялдуулан нэмэгдүүлсэн өөрчлөлтийг хийж байсан байна.



Хүснэгт 2. Төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын төсөв, төсөл, арга хэмжээний жагсаалтад оруулсан төсөв, төсөл, өөрчлөлтийн судалгаа /тэрбум төгрөг, тоо/



Эх сурвалж: Монгол Улсын төсвийн тухай хууль

Санхүүгийн нөөц хязгаарлагдмал, төсвийн орлогын бүрдэл хангалтгүй байсантай холбоотойгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлөх аж үйлдвэрийн чиглэлийн хөрөнгө оруулалт хийж чадаагүй, төсвийн хөрөнгө оруулалт нь ихэвчлэн дэд бүтцийг сайжруулах, нийгэмд тулгамдсан чухал хэрэгцээтэй байгаа сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга барих болон өмнөх онуудаас шилжсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг санхүүжүүлэхэд түлхүү чиглэгдэж байна.

Хөгжлийн банкны эх үүсвэрээс санхүүжиж байсан 127 төсөл, арга хэмжээний 184.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар улсын төсвөөс санхүүжүүлэхээр шилжүүлжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг салбараар нь ангилж үзэхэд 2017 оны хөрөнгө оруулалтын нийт хэмжээг өмнөх 5 жилийн дундажтай харьцуулахад 72.0 тэрбум төгрөгөөр буурсан ч дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалт салбарын ангиллаар /тэрбум төгрөг/

Салбарын ангилал	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	Өмнөх 5 жилийн дундажтай харьцуулбал
Дэд бүтэц	566.6	422.3	398.5	52.7	57.9	331	31.4
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт	154.3	107.1	191.4	91.7	100.9	104.3	(24.8)
Эрүүл мэнд	83.6	22.2	106.9	38.9	40.8	61.7	3.2
Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	16.5	17.1	23.9	14.6	23.9	7.8	(11.4)
Төрийн төв байгууллагууд	212.4	120.6	169.5	11.8	12.8	27.4	(78.0)
Хууль, батлан хамгаалах	14.6	55.3	27.8	33.5	8.5	39.2	11.3
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй	67.5	39.4	49.2	2	1.5	27.8	(4.1)
Хүнд үйлдвэр	4.1	3.8	4	1.6	57.9	2.8	(11.5)
Дүн	1,119.6	787.8	969.8	246.8	246.4	602.1	(72.0)

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл болон аудитын дүнд үндэслэв.



Төсвийн хөрөнгө оруулалтын 2017 оны гүйцэтгэлийг санхүүжилтийн эх үүсвэрээр өмнөх онтой харьцуулахад Хөгжлийн банкнаас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн санхүүжилт хасагдаж, харин улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт болон концессын гэрээний эргэн төлөлтөд олгох хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр /тэрбум төгрөг, хувь/


Санхүүжилтийн эх үүсвэр	2016 онд				2017 онд				Өсөлт (+), бууралт (-) 2017/2016
	ТАХ- ний тоо	Санхүү- жих дүн	Санхүүжилт Мөнгөн дүн	Хувь	ТАХ- ний тоо	Санхүү- жих дүн	Санхүүжилт Мөнгөн дүн	Хувь	
Улсын төсөв	293	303.6	246.4	81.2	373	602.1	539.6	89.6	355.7
Концессын эргэн төлөлт	3	70.7	70.7	100.0	15	177.7	176.2	99.1	105.5
Хөгжлийн банк	109	311.6	252.8	81.1	-	-	-	-	(252.8)
Нийт дүн	405	685.9	569.9	83.1	388	779.8	715.8	91.8	145.9

Эх сурвалж: Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хууль

Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 602.1 тэрбум төгрөгөөр 373 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн 354.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төслийн эргэн төлөлтөд 177.7 сая төгрөг олгохоор батлагдсан.

Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийг Сангийн яамнаас 91.8 хувьтай гэж тайлагнасан нь сүүлийн 5 жилийн дунджаас 9.3 хувиар өндөр үзүүлэлт болж байна.

Дүрслэл 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэлийн судалгаа /тэрбум төгрөг, хувь/



Эх сурвалж: Сангийн яам

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд Ерөнхий боловсролын сургуулийн 10340 суудалтай 18 сургуулийн барилга, өргөтгөл, 500 ортой 4 дотуур байр, 3570 ортой 32 цэцэрлэг, МСҮТ-ийн 130 суудалтай хичээлийн байр, 400 ортой дотуур байр, 110 ортой 8 хүн эмнэлэг, эмнэлгийн өргөтгөл, 65.3 км 3 чиглэлийн ЦДАШ, 4 дэд станц, 572.2 км автозам, 437.2 у/м төмөр бетон гүүр, 25 км бохир усны шугам, харин концессын “барих-шилжүүлэх” төрлөөр 4600 суудалтай 4 сургууль, 725 ортой хүүхдийн цэцэрлэг, 272.6 км автозам, 72.4 у/м гүүр тус тус ашиглалтад хүлээн авчээ.



Түүнчлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд ашиглалтад орсон төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг өмнөх 5 жилийн дундажтай харьцуулахад боловсролын салбарын барилга, байгууламжийн багтаамж, автозамын нэвтрүүлэх чадвар нэмэгдэж, харин бусад голлох салбаруудын хувьд буурсан байна.

Хүснэгт 4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон барилга, байгууламж /хүчин чадал/

Барилга, байгууламжийн ангилал	Хэмжих нэгж	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	Өмнөх 5 жилийн дундажтай харьцуулахад өссөн, буурсан
Хатуу хучилттай автозам	км	335	151	336	435	1171.9	176.6	844.8	390.7
Төмөр бетон гүүр	у/м	374	545	320	1259	586.2	289.9	509.6	(90.5)
ЦДАШ	км	459	743	636	472	562.4	65.3	-	(495.7)
Хүүхдийн цэцэрлэг	орны тоо	3270	3200	2150	3125	1820	2170	4,295	1,802
ЕБС, оюутны хичээлийн байр	суудлын тоо	5880	11558	6248	11183	7280	8008	15,070	6,215
Сургууль, МСҮТ-ийн дотуур байр	орны тоо	930	930	1430	1000	1270	620	900	(150)
Соёлын төв	суудлын тоо	1780	1890	1250	2000	2320	1400	-	(172)
Хүн эмнэлэг	орны тоо	310	200	270	445	460	545	110.0	(274)

Эх сурвалж: УАГ



Бүлэг 1.

Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдахгүй байна

Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тодорхой бодлого, хэрэгжих дарааллаар төлөвлөсөн гэх үндэслэл бага байна

1.1 Засгийн газрын 2012 оны 223 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын 2013-2017 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2012-2017 онуудад нийт 21.2 их наяд төгрөгийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгагдсан.

1.2 Дээрх хөтөлбөрт 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 4,886.7 тэрбум төгрөгийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан эх үүсвэрийн дүнтэй харьцуулахад 8.1 дахин их байгаа нь хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг үндэслэлтэй төлөвлөөгүй, Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8³-т заасны дагуу санхүүжүүлэх эх үүсвэрийг жил бүрийн улсын төсөвтэй уялдуулан тодотгол хийгээгүйтэй холбоотой байна.

1.3 Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан нийт 118 зорилтыг хэрэгжүүлэхэд 5,376.1 тэрбум төгрөгийн эх үүсвэр шаардлагатай гэж төлөвлөснөөс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 352.8 тэрбум төгрөгийн ажил хийхээр төлөвлөгджээ. Харин Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуулиар эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 60.4 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 9 төсөл, арга хэмжээнд 153.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан нь төлөвлөлтийн уялдаа хангагдахгүй байгааг харуулж байна.

1.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн хязгаарын саналаа Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 10-ны дотор хүргүүлнэ” гэж заасны дагуу ирүүлсэн саналыг үндэслэн 2017 оны төсвийн хязгаарыг боловсруулж, Засгийн газрын 2016 оны 346 дугаар тогтоолоор 15 ТЕЗ-дын хөрөнгийн зардлын хязгаарыг 312.2 тэрбум төгрөгөөр баталж, хүргүүлсэн байна.

1.5 Харин ТЕЗ-даас Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд тусгуулахаар 3,771.8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх, хөрөнгө оруулалтын 1,866 төсөл, арга хэмжээний санал хүргүүлж, төсвийн хязгаараас 12.1 дахин өндөр байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.4⁴ дахь заалттай нийцэхгүй байна. Тухайлбал,

- БСШУСС-ын 2016 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 1А/374 дугаар албан бичгээр 1,068.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн санал хүргүүлсэн нь батлагдсан хөрөнгийн зардлын хязгаараас 19.1 дахин их,
- ХНХС-ын 2016 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 1/51 дугаар албан бичгээр төсвийн төсөлд 71.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн санал хүргүүлсэн нь батлагдсан хөрөнгийн зардлын хязгаараас 39.6 дахин их,
- ЭХС-ын 2016 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн а/2104 дугаар албан бичгээр 757.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийн санал хүргүүлсэн нь батлагдсан хөрөнгийн зардлын хязгаараас 15.7 дахин их,
- БХБС-ын 2016 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 01/2065 дугаар албан бичгээр төсвийн төсөлд 965.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн санал хүргүүлсэн нь батлагдсан хөрөнгийн зардлын хязгаараас 69 дахин их байна.

1.6 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, жил бүрийн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн

³ Төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийн хүрээнд Засгийн газар улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг дөрвөн жилд нэг удаа баталж, жил бүр тодотгоно.

⁴ ТЕЗ өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах



н үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөхийг удирдлага болгож байгаа хэдий ч дунд хугацааны хөтөлбөртэй уялдуулаагүй, Засгийн газраас баталсан төсвийн хязгаарыг баримтлаагүй, төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй ихээхэн хэмжээний төсөл, арга хэмжээг саналд тусган өргөн барьсан хэвээр байна.

1.7 ТЕЗ-дын төсвийн төсөлд өргөн барьсан төслүүдийг төсвийн тухай хуулиар батлагдсантай харьцуулахад 3,300.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ хасагдаж, 4,881.0 сая төгрөгөөр санхүүжих, 10,958.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд нэмэгдэж батлагдсан байна. Тухайлбал ТЕЗ-даар харуулбал,

УИХ-ын даргын багцад:

- 1,688.0 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмж худалдан авах ажил,

ХХААХҮС-ын багцад:

- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/, 2,970.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2017 онд 554.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй,
- Хүнс, барааны худалдааны төвийн барилга /Хөвсгөл, Мөрөн сум/ 4,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2017 онд 558.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй,

ЭМС-ын багцад:

- Хавдар судлалын үндэсний төвийн сити томографын аппарат /УБ, БЗД/ шинээр хэрэгжих 2,100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил тус тус нэмэгдсэн байна.

1.8 Төсвийн тухай хуулиар төсвийн хязгаар батлагдаагүй 6 ТЕЗ-д 11,820.8 сая төгрөгийг баталснаас гадна 10 ТЕЗ-д 338,706.6 сая төгрөгийг төсвийн хязгаараас давуулан, 4 ТЕЗ-д хязгаараас 59,148.5 сая төгрөгөөр бага хөрөнгийн санхүүжилтийг баталжээ. Үүнд:

Хөрөнгийн зардлын хязгаар батлагдаагүй:

- БХС-ын багцад 4,896.9 сая, МУЕС-д 2,778.0 сая, УИХ-ын даргад 1,688.0 сая, ГХС-ын багцад 1,518.2 сая, Авлигатай тэмцэх газрын даргад 851.4 сая, Улсын Ерөнхий прокурорт 88.3 сая төгрөг,

Хөрөнгийн зардлын хязгаараас давуулж:

- ЗТХС-ын багцад 94,719.7 сая, ЭХС-ын багцад 64,904.1 сая, БХБС-ын багцад 59,832.3 сая, БСШУСС-ын багцад 48,400.1 сая, ЭМС-ын багцад 32,582.5 сая, ХХААХҮС-ын багцад 14,875.5 сая, ХЗДХС-ын багцад 11,133.6 сая, ХНХС-ын багцад 6,014.8 сая, ЗГХЭГ-ын даргад 4,725.8 сая төгрөгийн хөрөнгийг тус тус хязгаараас давуулан баталжээ.

1.9 Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд 2 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулснаар нийт 2,503,353.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 373 төсөл, арга хэмжээнд 602,107.1 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсан. Үүнд:

Хүснэгт 5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад орсон өөрчлөлт /тоо, тэрбум төгрөг/

Хөрөнгө оруулалтын ангилал	Төсвийн тухай хууль /2016.11.10-нд батлагдсан/			Хуулийн нэмэлт, өөрчлөлт /2017.04.14-нд батлагдсан/			Хуулийн нэмэлт, өөрчлөлт /2017.10.26-нд батлагдсан/			Зөрүү нэмэгдсэн +/-, хасагдсан -/		
	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүү-жих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүү-жих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүү-жих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүү-жих дүн
Хөрөнгө оруулалт	шинэ			2	20.4	20.4	12	104.6	96.6	12	104.6	96.6
	шилжих	167	942.3	195.5	302	2,156.0	321	2,200.0	385.2	154	1,257.7	189.7
Концесс "барих-шилжүүлэх" гэрээний эргэн төлөлт		12	352.1	71.5	12	353.1	15	354.4	177.7	3	2.3	106.2
Хөгжлийн банкны санхүүжилтээр	119	1,013.0	172.8							(119)	(1,013.0)	(172.8)
Их засвар	шинэ	4	21.9	15.6	4	21.6	5	22.3	21.5	1	0.4	6.0
	шилжих	7	83.3	16.5	6	75.2	6	77.7	38.4	(1)	(5.5)	21.9
Тоног төхөөрөмж	шинэ	3	19.7	19.7	5	28.1	13	44.4	41.3	10	24.7	21.6
	шилжих	3	4.4	3.4	5	45.1	6	45.7	18.2	3	41.3	14.8
ТЭЗҮ	шилжих				9	8.7	10	8.7306	0.77	10	8.7	0.8
ДҮН	315	2,436.6	494.9	345	2,708.2	63.8	388	2,857.8	779.8	73	421.2	284.8

Эх сурвалж: УАГ



Төсвийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр анх батлагдсан хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтаас төсөл, арга хэмжээний тоо 73-аар, түүний дотор шинээр эхлүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээ 12, шилжих 35, концессын “барих-шилжүүлэх” гэрээгээр хэрэгжсэн төслийн эргэн төлөлт хийх 3, тоног төхөөрөмж шинээр худалдан авах 10, шилжих 3, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах 10 шинэ төсөл, арга хэмжээ тус тус нэмэгдсэн байна. Тухайлбал,

- 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 13 ТЭЗ-ийн 217,561.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 52 төсөл, арга хэмжээний 152,386.5 сая төгрөгийн санхүүжилтийг хасч, БХБС-ын багцад төсөл, арга хэмжээний тоонд өөрчлөлт оруулалгүйгээр төсөвт өртгийг 2,254.6 сая төгрөгөөр, санхүүжих дүнг 921.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.
- 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр эдийн засаг сэргэх хандлага ажиглагдсан туйлдуулан өмнөх өөрчлөлтөөр хасагдсан 154,624.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 11 ТЭЗ-ийн 42 төсөл, арга хэмжээний 114,971.1 сая төгрөгийн санхүүжилтийг нэмэгдүүлсэн байна. БХБС-ын багцаас 6,313.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг хасч, санхүүжих дүнг 7,482.6 сая төгрөгөөр, Сангийн сайдын багцын санхүүжих дүнг 1,842.0 сая төгрөгөөр тус тус бууруулжээ.
- Мөн Улсын Их Хурлын 2016 оны 81 дүгээр тогтоол, Хөгжлийн банкны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 42, 219 дугаар тогтоолуудын дагуу Хөгжлийн банкны эх үүсвэрээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжиж байсан төсөл, арга хэмжээнүүдийг МУШС, Сангийн сайд, БХБС, ЭХС, ЗТХС-ын багцад шилжүүлсэн байна.

Төсвийн тухай хуульд төлөвлөлтийн алдаатай, хуулийн шаардлага, бэлтгэл хангагдаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасаар байна

1.11 Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан 779.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийн:

- 56.8 хувь буюу 442.7 тэрбум төгрөгийг шилжин хэрэгжиж буй 343,
- 20.4 хувь буюу 159.4 тэрбум төгрөгийг шинээр хэрэгжих 30,
- 22.8 хувь буюу 177.7 тэрбум төгрөгийг концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжсэн 15 төсөл, арга хэмжээний эргэн төлөлтөд тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

1.12 Тайлант онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо өмнөх оноос 36 төслөөр буурсан боловч олгох санхүүжилтийн хэмжээ 36.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

1.13 Хэдийгээр цөөн арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч зураг, төсөв нь баталгаажаагүй, хүчин чадал зөрүүтэй, хэрэгцээ шаардлага тодорхойгүй 12,242.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулсан байна. Тухайлбал,

Баталгаажсан зураг, төсөвгүйгээр:

- ЭМС-ын багцад батлагдсан 10,500.0 сая төгрөгийн их засварын ажил,
- БСШУСС-ын багцад Баянхонгор аймагт 1,410.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10, Дундговь аймагт 6.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, Дорноговь аймагт 80.0 сая төгрөгийн засварын ажлыг тус тус баталгаажсан зураг, төсөвгүйгээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Хэрэгцээ шаардлага тодорхойгүй:

- ЭХС-ын багцад ямар байгууллагын санаачлага, хэний саналаар төлөвлөгдсөн нь тодорхойгүй, холбогдох баримт материал байхгүй “Холбооны 2 яндантай 2100 метр сувагчлалын зураг төсөл, барилга угсралтын ажил” гүйцэтгэх 252.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөлд 2017 онд 59.0 сая төгрөгийн санхүүжилт төлөвлөжээ.

1.14 Мөн зарим ТЭЗ барилга, байгууламжийн ангилалд их засвар, тоног төхөөрөмж худалдан авах, их засварын ангилалд тоног төхөөрөмж худалдан авах ажлыг нэгтгэн төлөвлөсөн нь төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.3-т “эдийн засгийн ангиллаар” батална гэсэн заалтыг зөрчжээ. Тухайлбал,

- БСШУСС-ын багцад их засварын ангиллаар нийт 2,095.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авах ажлыг баталсан.
- Шадар сайдын багцад нийслэлийн БГД-т 2015 оноос эхлэн баригдаж буй “Онцгой байдлын албаны командын байрны барилга”-ын 20,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд 1,200.0 сая төгрөгийн төсөвт



өртөгтэй хөрөнгө оруулалтын 1, тоног төхөөрөмж худалдан авах 18,800.0 сая төгрөгийн 1 ажлыг нэгтгэн хөрөнгө оруулалтын ангилалд төлөвлөсөн ба 2017 онд залруулга хийгдээгүй.

1.15 Зарим барилга байгууламжийн нэмэлт ажлын зураг, төслийг төсвийн тухай хуульд тусгахаас өмнө магадлал хийлгэж баталгаажуулаагүйгээр өртгийг нэмэгдүүлэн хуулиар батлуулсан байна. Тухайлбал,

- БСШУСС-ын багцын 8,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй УБ хотын ХУД-т баригдаж буй Соёлын өвийн барилгын нийт төсөвт өртөг 7,920.7 сая төгрөг, байгуулсан гэрээний дүн 7,733.7 сая төгрөг байхад Төсвийн тухай хуулиар хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад 8,000.0 сая төгрөгөөр буюу зөрүүтэй батлуулснаас гадна инженерийн шугам сүлжээний зураг, төсөлд магадлал хийгдээгүй байхад гэрээ байгуулсан ба уг зураг, төсөлд БХТ-ийн 2017.12.20-ны өдрийн 898/2017 дугаараар магадлал хийгдээж 832.8 сая төгрөгөөр баталгаажуулснаас өртөг нэмэгдсэн.
- БСШУСС-ын багцын 640 хүүхдийн сургуулийн барилга /УБ, СХД, 25 дугаар хороо/ төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртөг 3,840.0 сая төгрөг бөгөөд анхны төсөвт өртөг 3,654.4 сая төгрөг, нэмэлт ажлын төсөв 185.6 сая төгрөг байна. Нэмэлт ажлын төсвийг магадлалаар баталгаажуулаагүй, мөн анхны зурагтай холболт хийгээгүй.
- ЭМС-ын багцад Халдварт өвчин судлалын үндэсний төвийн III шатлалын лабораторийн барилга /УБ, БЗД/-ыг 20,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр төсвийн тухай хуульд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлуулсан боловч зураг, төсөлд магадлал хийгдээгүй, гэрээний дүнгээс 859.5 сая төгрөгөөр илүү тусгасан байна.
- ХНХС-ын багцын УБ хотын СБД-т баригдаж буй Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын төсөвт өртгийг 2017 онд 300.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэхдээ нэмэлт ажлын зураг, төсөвт магадлал хийлгээж баталгаажуулаагүйгээр тус тус батлуулсан байна.

1.16 Он дамжин хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын нийт 39 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 2017 онд 62,571.2 сая төгрөгөөр буюу 47.2 хувиар нэмэгдсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу/

1.17 Аудитаар дээрх төслүүдээс буй ижил хүчин чадалтай боловч төсөвт өртөг нь харилцан адилгүй 30,182.5 сая төгрөгөөр төсөвт өртөг нь нэмэгдсэн нийт 11 барилга, байгууламжийг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч төсөвт өртгийн тооцоололд мэргэжлийн шинжээчдээр дүгнэлт гаргуулав.

1.18 Мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлтээр төсөл, арга хэмжээг төсвийн тухай хуульд тусгахдаа баталгаажсан зураг, төсвөөр батлуулаагүйгээс 28,637.2 сая, барилгын салбарын норм, дүрэмд оруулсан өөрчлөлтийг тусгаж, төсвийг шинэчлэн тооцоолсноос 5,194.1 сая, гадна инженерийн шугам сүлжээ болон гадна тохижилтын орхигдуулсан ажлыг нэмж тусгаснаар 1,857.0 сая төгрөгөөр тус төсөвт өртөг нэмэгдсэн байна.

1.19 Харин 4 барилга, байгууламжийн материалын үнийг зах зээлийн үнээс өндрөөр тооцсоноос өртөг 3,476.3 сая төгрөгөөр үндэслэлгүйгээр нэмэгдсэн байна. Үүнд:

- БХБС-ын багцад УБ хотын дулаан хангамжийн 11 г, д Ө800-ийн гол шугамыг Ø1000 мм голчтой болгон өргөтгөх зураг төсөл, барилга угсралтын ажил /1 дүгээр хорооллын урд талаас баруун 4 замын уулзвар хүртэл, Павильон 19-өөс 3/11 холбоос хүртэл 3.4 км/-ын зураг зохиосон байгууллага евро стандартын шаардлага хангасан материал ашиглахаар зураг зааж, төсөв зохиогч үнэ тодорхойгүй шалтгаанаар баримжаалж тооцсоноос өртөг 3,419.7 сая төгрөгөөр,
- ЭМС-ын багцад Аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга /Хэнтий, Хэрлэн сум/-ын дотор ажлын өртгийн тооцоололд орсон тоосгон өргийн ажлыг үнийг хасахгүйгээр полистрол хавтангаар сольж хийхдээ 51.3 сая төгрөгийг давхардуулан авсан.
- ХНХС-ын багцын МСҮТ-ийн төвийн дотуур байр /Орхон, Баян-Өндөр сум/-ны өртөг 4.0 сая төгрөгөөр,
- МУШС-ын багцын Алтанбулаг чөлөөт бүсийн Сүхбаатар-Сэлэнгийн 25 км бохир усны шугам хоолойн ажил /Сэлэнгэ, Алтанбулаг сум/-ын өртөг 1.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

1.20 Дүгнэлтээс үзэхэд хэдийгээр ижил хүчин чадалтай ч тухайн барилга барих газрын хөрсний агууламж, газар хөдлөлтийн түвшин, барилга байгууламжийн бүтээц, хийцлэл, инженерийн шийдэл, орон нутгийн тээвэрлэлтийн зай зэргээс шалтгаалан төсөвт өртөг нь харилцан адилгүй байх боломжтой байна. Тухайлбал,



ОБЕГ-ын аврах, гал унтраах ангийн 4 барилгууд нь мэргэжлийн ангиллын хувьд Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн 1 дүгээр зэрэглэлийн буюу 10 машинтай, Говь-Алтай аймгийнх 2 дугаар зэрэглэл буюу 8 машинтай, Багахангай дүүргийнх 3 дугаар зэрэглэл буюу 4 машинтайгаас гараашийн байр нь талбай, эзлэхүүний хувьд ялгаатайгаас гадна барилгын талбайн хувьд Дархан-Уул /2,628 м²/, Сэлэнгэ /2,628 м²/, Говь-Алтай /2,484м²/ аймгийн аврах, гал унтраах ангийн барилгууд нь 3 блокоос бүрдсэн, Багахангай дүүргийнх /1,673м²/ нь 4 блокоос бүрдсэн байна. Газар хөдлөлийн түвшин Говь-Алтай аймагт 9 балл, бусад 3 аймагт 8 баллын бүсэд байрлалтай.

- Хэнтий аймгийн Биндэр сумын 640 хүүхдийн /2,341.8м²/ сургууль хичээлийн 3 блок, спорт заал, халаалтын тогооны барилгатай, Увс аймгийн Тариалан сумын 640 хүүхдийн сургууль /4,482 м²/ хичээлийн 2 блок, ажилчдын байр, хурлын заалны 1 блок, спорт заал, халаалтын тогооны барилгатай, Архангай аймгийн Эрдэнэмандал сумын 640 хүүхдийн сургууль /4,159.35 м²/ хичээлийн 4 блок, спорт заалтай байх жишээтэй.
- Говь-Алтай аймгийн Алтай сумын 240 хүүхдийн сургууль /1,015м²/ нь 1 блок, халаалтын тогооны барилга, гадна цахилгаан, цэвэр бохир ус, дулааны шугам, зам талбайн ажил, 40 м³ бохирын цооногтой бол Булган аймгийн Гурванбулаг сумын 240 хүүхдийн сургууль /1,014.7 м² / хичээлийн 1 блок, спорт заалтай, хаалттай дэд өртөө, халаалтын тогоо, худгийн барилга, гадна холбоо, зам талбай, дулааны шугам, цэвэр бохир ус, 40 м³ бохирын цооногийн ажил хийгдсэн.
- Говь-Алтай аймгийн Цогт сумын 100 ортой дотуур байр /977.3 м²/ нь, Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын 100 ортой дотуур байр /1,177.4 м²/ адилхан 2 давхар 1 блок, халаалтын тогооны барилгатай ч барилгын талбайн хэмжээ инженерийн байгууламжийн шийдэл нь ялгаатай зэргийг дурдаж болохоор байна.

1.21 Гэвч ихэнх барилгуудын хувьд төсөвт өртгийг Төсвийн тухай хуульд анх батлуулахдаа зураг төсөвгүйгээр тойм тоогоор тусган, зураг төслийг нь хэсэгчлэн хийлгэж, магадлалаар баталгаажуулахад зурагт тусгагдсан ажлын тоо хэмжээг дутуу тооцсон, цаг уур, газар хөдлөлийн түвшинг буруу тогтоосон, барилгын норм дүрмийг баримтлаагүй зэргээс төсөвт өртөгт нь дахин магадлал хийгдэх шаардлага үүсч өртөг нэмэгдсэн байна. Мөн шинжээчийн ажлын үр дүнгээр дээрх барилгуудын ажлын явцад дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Говь-Алтай аймгийн Алтай сумын 240 суудалтай сургуулийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд гарсан 23.1 сая төгрөгийн магадлашгүй ажлын зардлыг хурлын тэмдэглэл, акт үйлдэж баталгаажуулалгүйгээр олгосон ба ямар ажлын зардал болох нь тодорхойгүй.
- Булган аймгийн Гурванбулаг сумын 240 суудалтай сургуулийн барилга угсралтын ажлын зураг төсөвт магадлалын ерөнхий дүгнэлт гаргаагүй, төсөвт өртгийг 2015 онд 863.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн боловч ямар шалтгаанаар өссөн талаар баримт материал байхгүй.

1.22 Барилга угсралтын ажлын төсөвт өртгийн тооцооллыг хийх, баталгаажуулах эрх бүхий байгууллагууд Барилгын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4⁵ дэх хэсэгт зааснаар төсөвт өртгийн өөрчлөлтийн тооцооллын үндэслэлийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байна.

1.23 Цаашид барилга угсралтын ажлын зураг, төсөлд магадлал хийхдээ барилга, инженерийн шугам сүлжээ, гадна тохижилтын ажил, техникийн нөхцөлүүдийг шийдвэрлэх асуудлыг иж бүрэн, цогц байдлаар шийдвэрлэгдсэний дараа баталгаажуулалт хийж, хуульд иж бүрэн өртгөөр нь тусгаж байх шаардлагатай байна.

1.24 ЗТБХБС-ын /хуучин нэрээр/ 2010 оны 107 дугаар тушаалаар батлагдсан Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалтын БНБД 12-01-09-ийн 5.1-т “Барилгын үйлдвэрлэлийн бэлтгэл ажилд дараах ажлууд хамаарна, ...газрын зөвшөөрөл авах, баригдах барилга байгууламжийн холбох техникийн нөхцөл авах” гэж заасныг баримтлалгүйгээр бэлтгэл ажил хангагдаагүй төсөл, арга хэмжээний зөрчлийг арилгах арга хэмжээ авалгүйгээр дахин хөрөнгө төлөвлөж байгаа нь төлөвлөсөн хөрөнгө ашиглагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал,

- БСШУСС-ын багцад ХУД-ийн Соёлын өвийн төвийн барилгын угсралтын ажлыг 2014 оноос эхлүүлсэн боловч 2017 оны 12 дугаар сар хүртэл бүх төрлийн техникийн нөхцөлүүд олгогдоогүй байхад барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

⁵ Барилгын материалын үнэ болон ханшийн өөрчлөлт бусад хүчин зүйлсээс хамаарсан барилгын төсвийн тооцоонд өөрчлөлт оруулах тохиолдолд санхүү, эдийн засгийн болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтарч үндэслэл тооцоог хянаж, сахүүжүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэнэ.



ЭХС-ын багцад 18,903.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2017 онд 3,290.6 сая төгрөгийн санхүүжилт элэх 4 төслийн газар чөлөөлтийн асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүй байхад 2017 онд үргэлжлүүлэхээр төлөвлөсөн.

- БХБС-ын багцад УБ хотын СХД-ийн 5, 6 дугаар хороо, Ханын материал орчмын гэр хорооллын цэвэр усны 1788 метр шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил хэрэгжих хугацааг 2014-2017 он гэж,
- ЭХС-ын багцын УБ хотын 12а магистралйн ТК-1211 цэгээс урагш гарсан 2 Ø400 мм голчтой шугамыг 2 Ø500 мм болгон өргөтгөх, 3х500х70 хүчин чадалтай шинээр даралт өргөх насос станц барих, зураг зохиох ажлын хэрэгжих хугацааг 2015-2017 он гэж,
- ЭХС-ын багцын 220 кВ-ын Улаанбаатар дэд станцаас 14 дүгээр хорооллын дэд станц хүртэлх 110 кВ-ын 9.7 км 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил, хэрэгжих хугацааг 2014-2017 он гэж,
- ЭХС-ын багцын УБ хотын БГД-т хэрэгжих 110 кВ-ын Баянгол дэд станцаас 110 кВ-ын Радио телевиз дэд станц хүртэлх 110 кВ-ын 24 км, 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг, барилга угсралтын ажил гүйцэтгэх хугацааг 2014-2017 он байхаар тус тус төлөвлөсөн.

1.25 Шүүх байгууллагаас шийдвэр гарсан төслүүдийн төсөвт өртөг, ханшийн зөрүү, хүү торгуулийн төлбөрт 2017 онд нийт 28,887.7 сая төгрөгийг олгохоор батлуулж, 28,873.4 сая төгрөгийг олгосон нь хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж, тухайн арга хэмжээний хувьд төсөл, арга хэмжээг төсвийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн эсэхийг тодорхойлох боломжгүй болгож байна. Тухайлбал,

ЭХС-ын багцад:

- Төсөл, арга хэмжээ нь 2007 оноос хэрэгжиж эхлэн дууссан боловч 2017 онд гүйцэтгэгч талд шүүхийн шийдвэрийн төлбөрийг барагдуулах зориулалтаар үлдэгдэл санхүүжилт нэрээр 878.3 сая төгрөгийн төсөвт өртөг, санхүүжих дүн бүхий "Буман нарны гэрэл үндэсний хөтөлбөрийн хүрээнд нарны цахилгаан үүсгүүр нийлүүлэх ажлын үлдэгдэл санхүүжилт /улсын хэмжээнд/" нэрээр хөрөнгө баталсан.

ЗТХС-ын багцад:

- "Арвайхээр-Баянхонгор чиглэлийн автозам 50 км" ажлын дутуу санхүүжилт 394.9 сая төгрөг,
- "Улаанбаатар-Эрдэнэсантын 168.2 км хатуу хучилттай автозам" ажлын дутуу санхүүжилт 4,275.7 сая төгрөг,
- "Мандалговь-Даланзадгад чиглэлийн 83 км хатуу хучилттай автозам" ажлын дутуу санхүүжилт 2,391.0 сая төгрөг,
- "Өндөрхаан-Мөнххаан-Баруун-Урт чиглэлийн 45.3 км хатуу хучилттай автозам" ажлын дутуу санхүүжилт 7,867.2 сая төгрөг,
- Аймгийн төвийн хатуу хучилттай автозамын 7 уулзварын өргөтгөн шинэчлэх болон замын засвар шинэчлэлийн ажил /Сүхбаатар, Баруун-Урт сум/ 2,249.3 сая төгрөг,
- Аймгийн төвийн 3 дугаар тойргийн хатуу хучилттай автозамын засвар шинэчлэлийн ажил /Сүхбаатар, Баруун-Урт сум/-д 3,717.4 сая,
- "Элсэн тасархай-Хархорины Орхоны гүүр чиглэлийн 77 км хатуу хучилттай автозамын шинэчлэл /Өвөрхангай/" ажлын дутуу санхүүжилтэд 4,265.7 сая төгрөг, нийт 25,161.2 сая төгрөгийг батлуулж шүүхийн шийдвэрийн дагуу нэр бүхий төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч болох 7 ААН-д холбогдох байгууллагуудын зөвшөөрөл бүхий албан бичгийн дагуу санхүүжүүлсэн байна.

УУХҮС-ын багцад:

- УБ хотын СХД-т 2012 онд баригдаж эхэлсэн 21,900.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Рашаантын газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн агуулах барих ажлыг концессын гэрээгээр хэрэгжүүлэх болсноос шалтгаалан улсын төсвөөр хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан өмнөх гүйцэтгэгчийн хийсэн ажлын гүйцэтгэлд 2,848.2 сая төгрөг олгохоор батлагдаж, санхүүжүүлсэн.

1.26 Энэ нь төрийн байгууллагууд бодлого, хөтөлбөртэй нийцүүлж шийдвэр гаргаагүй, захиалагч болон эрх бүхий албан тушаалтны алдаатай, ажлын хариуцлага алдсан үйл ажиллагаанаас шалтгаалж хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулсан байна.

1.27 Салбар хариуцсан яамд зураг, төсөл болон нэмэгдэл ажлын өртөгт мэргэжлийн байгууллагаас магадлал хийж, дүгнэлт гаргаагүй, өртгийн тооцоолол алдаатай хийгдсэн төсөл, арга хэмжээнд төсвийн төлөвлөлтийн шаардлага хангасан эсэхэд хяналт хийлгүйгээр жагсаалтад батлуулсанаас гадна шилжих барилга, байгууламжуудын ажлын явц, гүйцэтгэлийн байдалд захиалагч болон зохиогчийн техникийн хяналт, зөвлөх үйлчилгээний байгууллагуудын зүгээс тавих хяналт сул байгаагаас гүйцэтгэл дутуу байхад санхүүжилт батлагдаж байна.



Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуулиар хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг үнэлээгүй, хуульд заасан төлөвлөлтийн шаардлага хангаагүй байхад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 3.6⁶, 3.7⁷ дахь заалтыг мөрдөж ажиллаагүйгээс шалтгаалж, Төсвийн тухай хууль болон Барилгын тухай хуулийн холбогдох заалтууд зөрчигдөх үндэслэл болсоор байна.

⁶ ТЕЗ, аймаг нийслэлийн тухайн санхүүгийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсвийн хөрөнгө оруулалтын төсөв нь тухайн захиалагчийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй харилцан уялдсан байхын зэрэгцээ салбарын гол тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалтын ач холбогдол, тухайн төслийн хэрэгжилттэй уялдуулан эрэмбэлсэн байна.

⁷ Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн хүрээний мэдэгдлийг үндэслэн аймаг, орон нутгийн хэрэгцээ болон саналыг салбарын бодлоготой уялдуулан, өгөгдсөн санхүүгийн эх үүсвэр, төсвийн хягзаарт багтаан төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төслийг боловсруулна.




Бүлэг 2.

Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, тогтоомж, журмын холбогдох заалтыг бүрэн мөрдөхгүй байна

Дүрслэл 4. Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан хэлбэр /тоо/




2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд 517,882.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 208,071.7 сая төгрөгөөр санхүүжих 219 төсөл, арга хэмжээг 642 багцад задалж, худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас нээлттэй шалгаруулалтын журмаар 331 буюу 51.6 хувийг, хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмаар 2 буюу 0.3 хувийг, харьцуулалтын аргаар 246 буюу 38.3 хувийг, шууд гэрээ байгуулах аргаар 63 буюу 9.8 хувийг зохион байгуулсан байна.

Эх сурвалж: УАГ

2.2 ТЕЗ нар 2017 оны худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны 62.5 хувийг эхний хагас жилд 37.5 хувийг сүүлийн хагас жилд байгуулсан байна.

Дүрслэл 5. ТЕЗ-дын үнэлгээний хороо байгуулагдсан хугацаа /сар, тоо/



Эх сурвалж: УАГ

2.3 Зарим үнэлгээний хороод ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47.6⁸, 49⁹ шаардлагыг хангаагүй, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна. Тухайлбал,

Дорноговь:

- Номын сангийн барилгын засварын ажлын техникийн тодорхойлолтод ажлын тоо хэмжээ, нэр төрлийг зөрүүтэй тусгасан,
- Мөн 265.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий цэцэрлэг, сургуулийн барилгын үнийн саналыг хянахдаа төсөвт өртгийн нэмэгдэл зардлыг буруу тооцсон,

Дундговь:

- Үнэлгээний хороонд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшээгүй албан тушаалтан ажиллуулж, тендер шалгаруулалтын баримтаар архивын нэгж үүсгэхдээ шаардлагатай баримтыг дутуу бүрдүүлсэн,

Сэлэнгэ:

- Үнэлгээний хороог төсөл, арга хэмжээг захиалагч байгуулаагүй орон нутгийн өмчийн харилцааны газраас байгуулсан бөгөөд захиалагчид үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүлээгүй, архивын нэгжийг бүрэн бүрдүүлээгүй байна.

Улаанбаатар:

⁸ Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна.


⁹ Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална.



ийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 15 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан 7 үнэлгээний хороо гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа 11 тендерийн архивын нэгжид хуулийн 27 дугаар хэсэгт заасан "Тендерийг хянан үзэх", 28 дугаар хэсэгт заасан "Тендерийг үнэлэх" хүснэгтийг бүрдүүлээгүй, 3 тендерийн баримтад хуулийн 21 дүгээр хэсэгт заасан "Тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлсэн тухай баримт, хүргүүлсэн урилга" байхгүй, 5 тендерийн баримтад хуулийн 47.3.2-д заасан шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлсон "мэдүүлэг" байхгүй, 5 тендерийг явуулахдаа хуулийн 47.6 дахь хэсэгт заасан "Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна" гэсэн заалтыг хангасан эсэхийг тодорхойлох баримтыг хавсаргаагүй байна.

2.4 Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч нарт 2017 оны эхний хагаст 31.4 хувийг, харин 3 дугаар улиралд 30.4 хувь буюу 188, 4 дүгээр улиралд 38.2 хувь буюу 236 гэрээний эрхийг тус тус олгосон нь худалдан авах ажиллагааг зохион байгуулахад хугацаа алдсан, оны эцэст тендерийн хэмнэлтээс 1,024.7 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас шалтгаалсан бөгөөд хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн байна.

Дүрслэл 6. Худалдан авах ажиллагааны үр дүнгээр гэрээ байгуулах эрх олгосон хугацаа /сар, тоол



Эх сурвалж: УАГ

2.5 ТӨБЗГ-ын 2017 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөгөөр 12 төсөл, арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөснөөс бүгд хугацаандаа хийгдээгүй байна. Тухайлбал,

- Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн өргөтгөлийн тоног төхөөрөмж /УБ, СБД/ -ийн тендер шалгаруулалтад 67 хоног, гэрээ байгуулах эрх олгоход 79 хоног;
- Сургуулийн барилга, спорт заал /Завхан, Цэцэн-Уул сум/ тендер шалгаруулалтад 4 хоног, гэрээ байгуулахад 79 хоног;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/ худалдан авах тендер шалгаруулалтад 104 хоног,
- Төрөх эмнэлэг, 50 ор /Говь-Алтай, Есөнбулаг сум/ тендер шалгаруулалтад 142 хоног, гэрээ байгуулах эрх олгоход 150 хоног;
- Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Говь-Алтай, Цээл сум/ худалдан авах тендер шалгаруулалтад 252 хоног, гэрээ байгуулах эрх олгоход 276 хоног;
- Эрүүл мэндийн төвийн барилга /Дундговь, Дэлгэрхангай сум/ тендер шалгаруулалтад 143 хоног, гэрээ байгуулах эрх олгоход 144 хоног;
- Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/ тендер шалгаруулалтад 14 хоног, гэрээ байгуулах эрх олгоход 242 хоног;
- Хорооллын доторх зам, тохижилт /УБ, СХД/ тендер шалгаруулалтад 73 хоног, гэрээ байгуулах эрх олгох хүртэл 235 хоног;
- Дарь-Эх цогцолборын автозамын ажлын /УБ, БЗД, 21 дүгээр хороо/ тендер шалгаруулалтад 260 хоног, гэрээ байгуулах эрх олгох хүртэл 258 хоногийг тус тус зарцуулжээ.

2.6 Зарим ТЕЗ худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийг зөрчиж төсөвт өртгийг хуваан тендер зарласан, сонгон шалгаруулалт хийхдээ шалгуур үзүүлэлтийг баримтлаагүй, гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй байхад гэрээ байгуулсан байна. Тухайлбал,



ийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасны дагуу Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг баримтлаагүй:

- ХХААХҮС-ын багцад Хөдөө аж ахуйн салбарын мал эмнэлгийн яаралтай дуудлагын машин 730.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг 8 багцад хувааж, 1 багцад нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэж, бусад багцад харьцуулалт, шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэсэн,

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь заалтыг зөрчиж төсөвт өртгийг хэсэгчилэн хуваасан:

- ЭМС-ын 2017 оны А/418 дугаар тушаалаар их засварын төсвийн задаргааг батлахдаа босго үнэд багтаах, нээлттэй тендер шалгаруулалтын журам хэрэглэхээс зайлсхийх зорилгоор төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулсан.

Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-т "Нээлттэй тендер шалгаруулалтын тухайд тендер хүлээн авах эцсийн хугацааг 30 буюу түүнээс дээш хоноогоор тогтооно" гэж заасныг зөрчсөн:

- Кракуль үүлдрийн хонины аж ахуй байгуулах, Суффольк, меринос, роман, беричон душор үүлдрийн хонины аж ахуй байгуулах, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах, сүүний чиглэлийн өндөр ашиг шимт үхрийн аж ахуй байгуулах төсөл, арга хэмжээний Багц-1 "Сүү болон сүү-махны, махны чиглэлийн арвин ашиг шимт үхрийн үржлийн аж ахуй байгуулах" ажлуудын тендер шалгаруулалтын хугацаа нь тус бүр 11, 14, 3, 9 хоног байна.

Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасныг зөрчиж шалгарсан гүйцэтгэгчтэй хуулийн хугацаанд гэрээ байгуулаагүй:

- ЗТХС-ын багцад Япон улсын Засгийн газрын санхүүжилтээр Хөшигтийн хөндийд олон улсын нисэх онгоцны буудал барих төслийн хүрээнд дотоодын эх үүсвэрээс баригдах шуудан, ачаа, тээвэр, захиргаа үйлчилгээний барилгын гүйцэтгэгчээр шалгарсан байгууллагатай тендерийн хүчинтэй хугацаанд гэрээ байгуулаагүйгээс арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа хойшилсон. Үүнээс шалтгаалж эдгээр барилгын гадна талбайн 570.2 сая төгрөгийн ландшафтын ажлууд хийгдээгүйгээс Засгийн газрын хүлээх үүргийн биелэлт, зээлийн хөрөнгийн ашиглалт хангалтгүй байхад хүргэсэн.
- ХНХЯ-ны барилгын А блок буюу хуучин барилгад их засвар хийх тендерт оролцогчдод тавьсан шалгуурт "...цутгамал болон угсармал, төмөр бетон, мод ба өрөгт бүтээц болон иж бүрэн цутгамал бүтээц бүхий барилгын ажил 1-16 давхар хүртэл..." гэсэн шалгуураар хамгийн өндөр үнэ бүхий (259.9 сая төгрөг) тендерийг шалгаруулан, гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй байхад "Тэргэн нүүр" ХХК гэрээ байгуулан хэрэгжүүлсэн нь цөөн тооны аж ахуй эрхлэгчдэд давуу байдал олгосон, бусад аж ахуй нэгжийн өрсөлдөөнийг хязгаарласан.
- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын их засварын арга хэмжээнүүд нь зураг төсөвгүй байсан бөгөөд ТАХ-ний худалдан авах ажиллагааг нэг үнэлгээний хороо зохион байгуулж ажилласан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47.2¹⁰-т заасантай нийцэхгүй бөгөөд 4 тендерт шаардлага хангасан тендер ирээгүй гэсэн үндэслэлээр түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр шууд гэрээ байгуулан хэрэгжүүлсэн.

Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2¹¹, 34.1.3¹², 34.1.4¹³-д заасан шууд гэрээ байгуулах нөхцөл үүсээгүй, нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 15 хувиас хэтэрсэн ажилд дээрх хуулийн 8 дугаар зүйлийн 8.2¹⁴-т заасныг зөрчиж шууд гэрээ байгуулсан:

- БОАЖС-ын багцын "Ойн ангийн конторын барилга /Отгонтэнгэрийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа, аймгийн БОАЖГ/" төслийн хүрээнд хийгдсэн анхны гэрээний үнэ 618.1 сая төгрөгийн үнийн дүнгийн 31.8 хувийг эзлэх 196.8 сая төгрөгийн нэмэлт ажилд нээлттэй тендер зарлалгүйгээр өмнөх гүйцэтгэгч "Зост өргөө" ХХК-тай шууд гэрээ байгуулсан.
- БСШУСС-ын багцын Орхон аймгийн Баян-Өндөр сумд баригдаж буй 150 ортой цэцэрлэгийн барилгын ажлын анхны гэрээний үнийн дүн 1,077.8 сая төгрөг байхад захиалагч анхны гэрээний үнийн дүнгийн 15 хувиас хэтэрсэн 184.9 сая төгрөгийн нэмэлт гэрээг шууд аргаар байгуулсан.

Хуулийн 43 дугаар зүйлийн 43.4-т "Захиалагч дор дурдсан нөхцөлд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг гүйцэтгэгчээс шаардана. 43.4.1-д 150.0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ажил худалдан авах гэрээ байгуулах" гэж заасныг зөрчсөн:

¹⁰ 47.2 дах заалт Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх.

¹¹ оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар гэрээг зөвхөн нэг этгээдтэй байгуулах боломжтой бөгөөд түүнийг орлох этгээд байхгүй бол;

¹² нэмэлт нийлүүлэлт нь анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол;

¹³ нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 15 хувь болон энэ хуулийн 8.1.1-д заасан харьцуулалтын босго үнийн аль багаас хэтрээгүй нөхцөлд тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил төстэй ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол;

¹⁴ Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.



ЭМС-ын багцад Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн харьяа түлэнхийн төвийн барилгын А, С блокны барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч "Цаст контрактин" ХХК-тай 2017 онд 6,300.0 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулахдаа 315.0 сая төгрөг, Б блокны барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч "Нутгийн зам" ХХК-тай 15,318.6 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулахдаа 766.0 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгаа гаргуулаагүй байна.

2.7 Энэ нь төсөв хэмнэх, илүү чадамжтай гүйцэтгэгч сонгох боломжийг алдагдуулж, төсөл, арга хэмжээний санхүүжилтэд батлагдсан улсын төсвийн болон зээлийн хөрөнгийн ашиглалтад сөргөөр нөлөөлж байна.

2.8 ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49.5-д “Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тухайн жилийн тайланг захиалагч 12 дугаар сарын 01-ний дотор ТЕЗ-д, ерөнхийлөн захирагч нь дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана” гэж заасны дагуу ТӨБЗГ-аас 2017 онд хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын тайланг 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн А-1/111 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн боловч мэдээлэл зөрүүтэй буюу нийт зохион байгуулагдсан 68 худалдан авах ажиллагаанаас 56 төсөл, арга хэмжээний мэдээллийг хүргүүлсэн байна.

2.9 Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль зөрчсөн үйлдэл гаргаж байгаа нь ТЕЗ-дын ажил хариуцсан ажилтнуудын ажлын хариуцлага сул, хариуцлагын тогтолцоо үйлчлэхгүй байгаатай холбоотой байна.

Барилгын салбарт мөрдөгдөх норм стандарт, дүрэм журмын шинэчлэлийг шуурхай зохион байгуулах шаардлагатай байна

2.10 Одоогоор барилгын салбарт нийт барилгын 422 норм ба дүрэм, 498 стандарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. БХБЯ, Барилгын хөгжлийн төвтэй хамтран 2014 онд ажлын хэсэг гаргаж, нийт 255 норм, нормативын баримт бичигт үзлэг хийж, 69 буюу 27.1 хувийг хэвээр мөрдөх, бусад норм, нормативын баримт бичгүүдэд материал, технологийн сонголт нь хоцрогдсон, 59 буюу 22.5 хувь нь өргөн хэрэглэгддэггүй хуучирсан тул хүчингүй болгох, 129 буюу 50.5 хувийг бүхэлд нь шинэчлэх эсвэл холбогдох заалтуудыг хүчингүй болгох дүгнэлт гаргаж байсан бол түүнээс 2017 оныг хүртэл 99 норм, нормативын баримт бичиг, стандартыг шинэчилсэн боловч мэргэжлийн болон техникийн зөвлөл ажиллаагүй, эцэслэн батлагдаагүй байна.

2.11 Хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга, байгууламжийн зураг төсөл зохиох, төсвийн тооцооллыг боловсруулах, барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд дараах нийтлэг алдаа, зөрчил гарч байна. Тухайлбал,

Сургууль, цэцэрлэгийн нэг маягийн зургийн хувьд:

- Барилгын нэг маягийн зурагт холболт хийхдээ эх зураг батлагдсанаас хойш барилгын салбарт нэвтэрч байгаа шинэлэг материал, технологийг тусгах ажил хийгддэггүй,
- Улаанбаатар хотын хувьд газар зохион байгуулалтаас шалтгаалан нэг маягийн зургаар сургууль, цэцэрлэг барихад тохиромжгүй болсон.
- Холболт хийхдээ барилгын хэсэгт зөвхөн суурийн өөрчлөлтийг оруулаад “0.00”-оос дээшхи хэсэгт өөрчлөлт оруулдаггүй,

Барилгын төсөв зохиох “Estimator-21 pro” программын хувьд:

- Программаас бетон эдлэлийн апалокыг модоор хийхээр, гадна дотор заслын ажилд хэрэглэгдэхээ больсон нойтон технологийн аргаар хийх сонголт гарч ирдэг.
- Барилгын салбарт нэвтэрч буй шинэ технологийн норм үнэлгээ байхгүйгээс төсөвчид өөрсдөө тохируулга хийх шаардлагатай болдог.
- Программд өөрчлөлт, шинэчлэлт хийгддэггүй зэргийг дурдаж болохоор байна.

2.12 Энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалт хэрэгжиж буй салбар бүрт норм нормативын тогтолцоо, тавигдах шаардлага, зарчим боловсруулах, батлуулах үйл ажиллагаа хоцрогдох, өөрчлөлт цаг үеэ олоогүй байх, шинэчлэл шаардах зэргээр төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд тогтвортой, үр нөлөөтэй үйлчлэхгүй байгаа тул цаашид барилгын зураг,



зохиох дүрэм, журмын мөрдөлт тэдгээрийн шинэчлэлт сайжруулалт, программ хангамжийн шинэчлэлт, хөгжүүлэлтийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн тухай бүрт шуурхай зохион байгуулж гүйцэтгэж байх шаардлагатайг харуулж байна.

2.13 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн томоохон арга хэмжээнээс дараах төслүүд зураг төсөл боловсруулалт, төлөвлөлтийн алдаанаас шалтгаалан үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд хүндрэл үүсээд байна. Тухайлбал,

- *Үндэсний номын сангийн барилга угсралтад олгосон газар олголтын хэмжээ бага, эзэмшил газрын 57.0 хувийг барилгажих талбай эзэлж, байгаагаас шалтгаалж ногоон байгууламж хийх боломжгүй болсон, гамшигаас урьдчилан сэргийлэх нөхцөл хангагдахгүйн ултаас улсын комисс ашиглалтад авах боломжгүй болсон.*

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт 80.7 хувийн гүйцэтгэлтэй байна

2.14 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд нийт 388 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 37 төсөл, арга хэмжээ буюу 9.5 хувь нь хэрэгжээгүй, 9.8 хувь буюу 38 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дутуу байна.

Хүснэгт 6. Хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний судалгаа /ТЕЗ, тоо, сая төгрөг/

№	ТЕЗ	Барилга, байгууламж			Тоног төхөөрөмж			НИЙТ		
		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	ХНХС	1	1,400.0	45.7	1	288.0	288.0	2	1,688.0	333.7
2	БХБС	9	25,337.3	6,591.2				9	25,337.3	6,591.2
3	БСШУСС	3	8,467.4	540.5	1	120.0	120.0	4	8,587.4	660.5
4	ЗТХС	9	119,372.0	2,392.7				9	119,372.0	2,392.7
5	ХХААХҮС	2	5,126.3	834.5				2	5,126.3	834.5
6	ЭМС	1	57.1	57.1				1	57.1	57.1
7	ЭХС	10	55,484.6	5,394.5				10	55,484.6	5,394.5
	ДҮН	35	215,244.7	15,856.2	2	408.0	408.0	37	215,652.7	16,264.2

Эх сурвалж: УАГ

2.15 Нийт 37 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйгээс 16,264.2 сая төгрөгийн санхүүжилтийг ашиглах боломж бүрдээгүй бөгөөд энэ нь нийт санхүүжилтэд батлагдсан хөрөнгийн 2.7 хувийг эзэлж байна. Төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй шалтгааныг дурдвал,

- *Гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь хэрэгжүүлээгүйгээс 9,861.7 сая,*
- *Газар чөлөөлөлт хийгдээгүй, газрын маргаан гарсны улмаас 1,821.2 сая,*
- *Шүүхийн маргаан гарч, шийдвэр эцэслэн гараагүйгээс 1,312.3 сая,*
- *Шаардлагагүй зүйлд хөрөнгө төлөвлөснөөс 1,297.3 сая,*
- *Худалдан авах ажиллагаа хүчингүй болсноос 861.3 сая,*
- *Тоног төхөөрөмж худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүйгээс 408.0 сая,*
- *Төлөвлөлтийн алдаанаас шалтгаалж холбох байгууламж ашиглалтад ороогүйгээс 340.3 сая,*
- *Барилга байгууламж ашиглалтад оруулах дүрмийн заалтыг зөрчсөнөөс 203.1 сая,*
- *Хэрэгжилт удааширснаас гэрээнд заасан үнийн дүнгээр худалдан авалт хийх боломжгүй болсноос 100.0 сая,*
- *Захиалагч байгууллага тодорхойгүйгээс 59.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус ашиглах боломжгүй байсан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос үзнэ үү/*

2.16 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнээс 38 төслийн хэрэгжилт дутуу байгаагаас 15,637.7 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр ашиглагдаагүй бөгөөд шалтгаанаар нь авч үзвэл, 18 буюу 47.4 хувь нь гүйцэтгэгч байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалж, 8 буюу 21.1 хувь нь санхүүжилт хугацаандаа олгогдоогүйгээс, 8 буюу 21.1 хувь нь хэрэгжүүлэх хугацааг оновчтой тодорхойлоогүйгээс, 3 буюу 7.9 хувь нь барилга, байгууламжийн гадна инженерийн шугам сүлжээний асуудал шийдэгдээгүйгээс, 1 төслийн зураг, төсөлд өөрчлөлт орж магадлалаар баталгаажуулахад хугацаа алдсанаас тус тус хугацаандаа хэрэгжээгүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас харна уу/



н төсвийн хөрөнгө оруулалтаар барих барилга, байгууламжийг нормативт хугацаанд ашиглалтад оруулдаг болгох шаардлагатай байна

2.17 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй нийт 333 төсөл, арга хэмжээний 76.7 хувь нь 4-өөс дээш жилийн хугацаагаар үргэлжилж, нийт баригдаж буй барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулах дундаж хугацаа 5 жил гарч байна.

Хүснэгт 7. Хөрөнгө оруулалтын хэрэгжиж буй ТАХ-ний үргэлжилж буй хугацаа /тоо, жил, хувь/

Ангилал	Хэрэгжилтийн үргэлжилж буй хугацаа, жилээр												Нийт тоо
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Барилга байгууламж	9	21	29	81	69	54	43	11	9	3	2	2	333
Төсөвт өртөг	73.0	79.3	148.1	431.9	540.6	274.0	552.3	89.0	81.1	21.5	3.2	10.6	2,304.6
Санхүүжих дүн	73.0	51.3	45.8	72.5	77.2	56.9	78.7	12.1	6.8	1.2	1.3	5.0	481.8
Эзлэх хувь	2.7	6.3	8.7	24.3	20.7	16.2	12.9	3.3	2.7	0.9	0.6	0.6	100.0
Барилга угсралтын ажлын ашиглалтад орох дундаж хугацаа, жилээр													5.0

Эх сурвалж: УАГ

2.18 Энэ нь төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон мэргэжлийн байгууллагын хяналт сул, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар цаг хугацаанд нь арга хэмжээ авдаггүй, төсөл, арга хэмжээ хэрэгжих хугацаанд тохирсон санхүүжилтийг хуваарилан төлөвлөж, санхүүжүүлээгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжтэй хариуцлага тооцохгүй байгаагаас хэрэгжилт нь удааширч, улмаар орхигдох шалтгаан болж байна.

2.19 БХБС-ын 2015 оны 193 дугаар тушаалаар баталсан “барилга, байгууламжийн ажил гүйцэтгэх хугацааны норм”-д зааснаар цэцэрлэгийн барилгыг дунджаар 6.8 сар, сургуулийг 11.8 сар, соёлын төвийг 10.2 сар, спорт залыг 5.5 сард барьж дуусгахаар нормчилсон байдаг.

2.20 Гэвч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1 барилга байгууламжийг барихад дунджаар 5 жилийг зарцуулж байгаа нь хэт урт хугацаа болж байна.

Барилга угсралтын ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн ажлын хариуцлага сул байгаагаас чанар муутай барилгууд баригдсаар байна

2.21 Гүйцэтгэгч байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалж төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширч, барилга угсралтын ажлын явцад барилгын норм дүрэм зөрчигдсөнөөс барилга угсралтын ажлууд чанаргүй хийгдэж байна. Тухайлбал,

БСШУСС-ын багцад:

- Хэнтий аймгийн Хэрлэн сумын 600 суудалтай “Хан хэнтий” чуулгын барилга угсралтын ажлыг “Хөвсгөл геолог” ХХК 2012-2014 онуудад гүйцэтгэхдээ барилгын норм, дүрэм зөрчиж, чанаргүй ажил хийснээс дээрээс борооны ус гоождог, зоорийн давхрын хамар ханын суурийг муу хийснээс нурж унасан, бетон хийцүүдийг цутгахдаа олон тасалж хийсэн, зарим хэсэгт баганыг муруй цутгасан, ган татангуудын бэхлэгээ муу хийгдсэнд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах шаардлагатай.
- УБ хотын СХД-ийн 25 дугаар хороонд баригдаж буй 3,840.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 640 суудалтай, 104 дүгээр сургуулийн барилгын гүйцэтгэгч “Фүжиг Алтай” ХХК барилгад хүүхдийн хүчинд чадалд хүрэлцэхээргүй буюу 40 м.кубын цооног хийснээс өдөр бүр 40.0 мянган төгрөг зарцуулж 5.8 тоннын даацтай автомашинаар бохирыг соруулах шаардлагатай болж урсгал зардлыг нэмэгдүүлсэн. Мөн сургуулийн анги, танхим, өрөөнүүдэд хийсэн модон хаалга, спорт заалны ханын эмульс шаардлага хангахгүй, сургуулийн цайны газар хийхээр төлөвлөсөн өрөө нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй, барилгын Б, В блокны дотор талын шовны завсараар ан цав гарч хагарсан, гадна талбайн тэгшилгээ, зүлэгжүүлэлт, ногоон байгууламжийн ажил хийгдээгүй байна.
- Сургуулийн барилга, 640 суудал /Завхан, Их-Уул сум/ төслийн гүйцэтгэгч “Ар Си Ти” ХХК барилгын 1,2 дугаар давхрын цутгалтыг хийхдээ хэвний тэгшилгээг хийгээгүй тул хучилт, дам нурууны түвшин бүхэлдээ алдаатай цутгагдсан.
- Сургуулийн барилга, 220 суудал /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/ төслийн гүйцэтгэгч “Ганцаг” ХХК тогооны барилга гадна ханын өргийн тэгш хэмийг алдагдуулж, өргийн мөр хоорондын зай, гадна болон дотор хөнгөн бетон блок, тоосгон өргийн шовны зузааныг норм дүрмийн хүлцэх алдаанаас хэтрүүлсэн.



-ын багцад:

Төрөх эмнэлэг 50 ор /Говь-Алтай, Есөнбулаг/ төслийн гүйцэтгэгч “Лайт капитал хаус” ХХК солигдож “Эсба интернэшнл” ХХК сонгогдсон боловч “Лайт капитал хаус” ХХК барилгын бетон цутгалтыг хийхдээ норм ба дүрмийг баримтлаагүйгээс чанаргүй хийгдсэн, батлагдсан зураг төслийг өөрчилж барилгын гадна ханын өнгөлгөөний материалыг өөрчилсөн, барилгыг ил далд ажлын акт, үе шатны ажлын фото зураг, барилгын ажлын журнал байхгүй байна.

- Төрөх эмнэлэг 50 ор /Дорноговь, Сайншанд/ төслийн гүйцэтгэгч “Монинжбар” ХХК солигдож, “Баярсонстракин” ХХК сонгогдсон боловч “Монинжбар” ХХК барилгын ажлыг гүйцэтгэхдээ 2014 оны 11 сард буюу хүйтний улиралд цутгалт хийснээс хөлдөж 1, 2 дугаар давхрын карказ, хучилт, цутгамал шат үйрч байсан тул буулгуулж дахин шинээр цутгалтын ажил хийсэн, мөн барилгыг буулгаад шинээр 1, 2 дугаар давхрын угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн боловч 2, 3 дугаар давхрын төмөр бетон карказын бетон хөлдөлттэй, багана, дам нуруу, хучилтыг тасалж цутгасан, гадна дүүргэлтийн ханын өрлөг нь анкер, деталгүй өрлөгийн сетка байхгүй, төмөр бетоны марк нь М250 маркийг хангахгүй дөнгөж 21.7-85.9 марктай, хучилтын зузаан 150 мм-т хүрэхгүй, зоорийн давхрын гадна хана 500 мм-ийн зузаантай бетон байсныг 300 мм-ийн зузаантай цутгаж батлагдсан зураг төсөл, техникийн шаардлагыг хангаагүй байна.

ЗТХС-ын багцад:

- Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 27 км автозамын ажлыг гүйцэтгэгч “Хансуун зам” ХХК ажлаа төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгээгүй, ажлын гүйцэтгэлийг хангуулахаар улсын комисс ажиллуулсан боловч тогтоосон хугацаанд үүрэг, даалгаврын хэрэгжилтийг гаргаж ирүүлээгүйгээс ажил зогсонги байдалд орсон.

БХС-ын багцад:

- 2013 оноос эхлэн хэрэгжсэн Говийн бүсийн сургалтын төвийн /Өмнөговь, Даланзадгад сум/ 200 цэргийн байрны барилга 4,233.2 сая төгрөгийн өртөгтэйгээр 2015 онд баригдаж, ашиглалтад орсон боловч байшингийн суурь хэсэгт суулт өгсөн, гадна фасад хууларсан, ариун цэвэр, усны өрөө, гал тогооны өрөөнүүдэд ашиглалтаас шалтгаалж чийг үүсэж, шалны хотойлт үүсэн завсар зай гарч, барилга хөдөлгөөнд орсон зэргээс ашиглагчийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй болсон тул 2016-2017 онуудад нэмэлт хөрөнгөөр халуун ус, халаалтын тогоо, гал тогооны өргөтгөлийн барилга, барилгын дотор халаалтын систем, гадна дулаан, цэвэр усны шугам, цэвэрлэх байгууламжийг нэмж барих ажлуудыг хийсэн байна. Энэ нь БХАҮН ТӨААТҮГ нь барилгын норм дүрмийн дагуу барилга байгууламжийг төлөвлөөгүй, барилга угсралтын ажлын гүйцэтгэгч “Изо хаус” ХХК батлагдсан зураг төслийн дагуу барилга угсралтын ажлыг гүйцэтгээгүй, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн БХАҮН ТӨААТҮГ хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

2.22 Цаашид ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн хариуцлагыг сайжруулж, барилга байгууламжийг дутуу орхих, төсвийн хөрөнгийг үргүйдүүлэх асуудлыг зогсоох шаардлагатай байгаа тул төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн үр дүнгээр хариуцлага хүлээлгэж байх тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид гэрээний хэрэгжилтэд тогтмол, чанартай хяналт тавихгүй, эрх мэдлээ хэтрүүлэн төсвийн хэмнэлтийг зарцуулсан байна

2.23 Захиалагч байгууллагын гэрээний үүргийн хэрэгжилтэд тавих хяналт сул байгаагаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэл чанаргүй, ажил дутуу, гүйцэтгээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгож байнгын ашиглалтад хүлээн авч байгаа нь нэмэгдэл зардал гарах эрсдэлийг дагуулж байна. Тухайлбал,

БСШУСС-ын багцад:

- 17,888.6 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 5 төслийн гэрээний хугацаанд сунгалт хийгээгүй, ажлын гүйцэтгэл 56.5-85.3 хувьтай;

ХНХС-ын багцад:

- Усан спортын цогцолбор /УБ, СХД, Найрамдал зуслан/-ын барилгын гадна дулааны техникийн нөхцөл өөрчлөгдсөнөөс шалтгаалан зураг, төсөлд өөрчлөлт орж нэмэлтээр хийгдэх 4 нэр төрлийн 1,613.4 сая төгрөгийн ажил, БНБД-ийн өөрчлөлтөөс шалтгаалж үүсэх зөрүүг тусгасан зураг, төсвийг шинэчлэн боловсруулж, баталгаажуулалт хийлгээгүй нь Барилгын тухай хуулийн 25.5-д заасныг зөрчиж, 40.1-д заасан үүргээ хэрэгжүүлээгүйгээс шалтгаалсан.

ЗТХС-ын багцад:

- Чиглэлийн автозамыг хугацаанд нь ашиглалтад оруулах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, гэрээний хэрэгжилтэд тавьсан хяналтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ аваагүй, гэрээг үндэслэл муутай дүгнэж байгаагаас Ховд аймгийн Булган-Үенч-Ховд чиглэлийн “Жиансу Жунишан Жиашиин” ХХК-ийн гүйцэтгэж буй 60 км автозам, Бүс нутгийн автозам хөгжүүлэх төслийн Сайншанд-Замын үүд



чиглэлийн хатуу хучилттай автозамаас Өргөн сум хүртэлх “Шинэ хөгжил зам” ХХК-ийн гүйцэтгэж буй 18.25 км хатуу хучилттай автозам, Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн “Чайна Гео Инженеринг” ХХК-ийн гүйцэтгэж буй 50 км автозам, Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн “Хансуун зам” ХХК-ийн гүйцэтгэж буй 27 км автозам, нийт 155.3 км автозам хугацаандаа ашиглалтад ороогүй.

БХБС-ын багцад:

- Барилгын материалын чанарт тавих хяналтыг сайжруулахын тулд 21 аймагт барилгын материалын сорил шинжилгээний лаборатори байгуулахаар төлөвлөж, гүйцэтгэгчээр 2013.09.12-нд “Цэцүүх трейд” 135 нэр төрлийн тоног төхөөрөмж, урвалж бодис нийлүүлэх 943.0 сая төгрөгийн гэрээг байгуулж, тухайн онд батлагдсан 500.0 сая төгрөгийн санхүүжилтийн хүрээнд 128 нэр төрлийн тоног төхөөрөмж болон химийн урвалж бодисуудыг 2013.12.18-ны өдөр актаар хүлээн авсан ч уг тоног төхөөрөмжүүдээ хадгалах байргүйгээс тус компаний агуулахад орхисноос 2017 оныг хүртэл хадгалагдсаар байгаа төслийг хэрэгжүүлж дуусгах талаар БХБЯ, БХТ дорвитой арга хэмжээ аваагүй ч дахин хөрөнгө төлөвлөж гүйцэтгэгчийн өмнө нь худалдан авсан 45 нэр төрлийн 61.4 сая төгрөгийн химийн урвалж бодисуудыг худалдан авахаар нэмэлт гэрээ байгуулан 2018.01.15-ны өдөр хүлээн авч, орон нутгийн лабораториудад нийлүүлсэн байна.

ХНХС-ын багцад:

- Усан спортын цогцолборын барилгын ажилд захиалагчийн хяналтыг гүйцэтгүүлэхээр “Их барилгын зөвлөх” ТББ-тай 2015.04.16-нд 133.1 сая төгрөгийн хамтран ажиллах гэрээг байгуулсан бөгөөд уг ТББ хяналтыг хэрэгжүүлэхдээ захиалагчтай албан ёсоор зөвшилцөлгүйгээр, Олон улсын Найрамдал төвийн тухайн үеийн удирдлагуудын саналыг үндэслэн барилгын дээвэр, суурийн багана зэрэг хэсгүүдэд зураг төсвийн өөрчлөлт оруулах, VIP өрөөний тоо хэмжээг нэмэгдүүлсэн зэрэг төлөвлөлт болон технологийн зарим шийдлийг оновчтой тодорхойлоогүй¹⁵ зааварчилгааг зураг төсөл боловсруулагч “Эгэ” ХХК-д өгч, өөрчлөлтийн зургийг магадлалаар хянуулж, баталгаажуулалгүйгээр барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлсэн, барилга угсралтын ажлын гүйцэтгэл 60.0 хувьтай байхад 80.0 хувийн ажлын гүйцэтгэлийг баталгаажуулсан, мөн ХНХЯ-наас зөвлөх инженер Д.Батсайхантай хамтран ажиллах гэрээ байгуулж, хяналт хийлгэхдээ өмнөх захиалагчийн хяналт гүйцэтгүүлэх гэрээг цуцлалгүйгээр хяналтыг давхардуулсан.
- Зөвлөх инженер Д.Батсайхан нь гэрээний дагуу ХНХЯ-ны хөрөнгө оруулалт, их засварын ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналт тавих үүрэгтэй ч ХНХС-ын багцаас харьяа агентлаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн зарим их засварын ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр давхар гэрээ байгуулан 4.5 сая төгрөгийн нэмэлт төлбөр авсан нь байгуулсан гэрээний “... ХНХЯ-ны салбарын хэмжээний барилга угсралтын ажил, их засварын ажилд хяналт тавин ажиллана” гэсэн заалттай зөрчилдөж байна.

2.24 Орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хувьд дээрх алдаа, зөрчил мөн адил давтагдан гарч байна. Тухайлбал,

Архангай:

- “Дэлгэр констракиш” ХХК нь Төвирүүлэх сумын спорт заалны барилгын зураг төсөвт тусгагдсан дээврийн ус зайлуулах хоолойг хийгээгүй байхад 2017 оны 10 дугаар сарын 3-ны өдөр ашиглалтад хүлээн авсан,
- “Гурван тамир” ХХК нь Батцэнгэл сумын сургуулийн барилгын их засварын ажлыг 2017 оны 7 дугаар сарын 21-ны өдрийн №2017/34 тоот улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан ч таазны будаг ховхорсон,
- “Голомт констракиш” ХХК нь Эрдэнэмандал сумын 640 хүүхдийн сургуулийн гадна тохижилтын ажлыг хийгээгүй, дотор заслын ажлууд дутуу байхад улсын комиссын 2017 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 43/2017 тоот актаар хүлээн авсан,
- Мөн сумын “БГБС” ХХК нь 100 хүүхдийн дотуур байрны засварын ажлын зураг төсөвт тусгагдсан гал тогооны өрөө рүү гаднаас шууд орох хаалгыг будах ажлыг гүйцэтгээгүй байна.

Баянхонгор:

- “Хорол багана констракиш” ХХК нь Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн бохирын цооногыг төрөх өрөөний хажууд байршуулсан, агааржуулалт муутайгаас мөөгөнцөр үүссэн нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй, бохирын хоолой доторх халаах утас шатсанаас ашиглалтгүй болсон.
- Баянговь сумын Соёлын төвийн барилгын зарим өрөөнд плита хийгдээгүй, дотор засал, дотор цахилгаан, гадна тохижилтын ажил дутуу байхад 2017 оны 12 дугаар сарын 1-ний өдөр улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээн авсан,

Булган:

- Булган сумын 150 ортой цэцэрлэгийн барилгыг 2017 оны 3 дугаар сарын 16-ны өдөр үүрэг даалгавар өгч ашиглалтад хүлээн авсан ч үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй, тухайн онд батлагдсан санхүүжилттэй уялдсан ажлын гүйцэтгэлгүй байна,

¹⁵ Эх сурвалж: 2017 оны 1 дүгээр сард Монгол Улсын Төсөвчдийн холбооноос мэргэжлийн төсөвчнийг татан оролцуулж уг төсөл, арга хэмжээний тендер зохион байгуулалт, барилгын ажлын хэрэгжилтэд Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас хийсэн хяналт шалгалтын тайлан



Алтай:

- Есөнбулаг сумын 4 дүгээр цэцэрлэгийн барилгын засварын ажлын гадна цонхны амалгаа хийгдээгүй байхад 2017 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн КА-020/2017 тоот улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан. Тус засварын ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр очин шалгахад заалны өрөөний шал овойсон, 3 ангийн тааз, хананы эмүльс хууларсан, гал тогооны өрөөний тааз хөгцөрсөн, хаалганы хүрээ суларч, бариул хугарсан зэргээр ашиглагчийн шаардлага хангаагүй байна.

Дорноговь:

- Сайнишанд сумын 6-р цэцэрлэгийн засварын ажлын гүйцэтгэгч “Хорго групп” ХХК нь ажлыг гүйцэтгэхдээ гантиг чулуун тавцанг гантиг өнгөтэй хуванцар бэлдцээр сольсон,
- Мандах сумын спорт заалны гүйцэтгэгч “Нэгдсэн Монгол” ХХК нь 240.1 м спорт заалны шалны резинен будгийг тосон будгаар сольсон,
- Замын-Үүд сумын 1 дүгээр цэцэрлэгийн гадна фасад, дээврийн засварын ажлын цоколь хэсгийг хиймэл хавтанцараар өнгөлөх ажил хийгдээгүй байхад 2017 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн КД-05/2017 тоот комиссын актаар ашиглалтад хүлээн авсан,

Завхан:

- Алдархаан сумын цэцэрлэгийн дээврийн засварын ажил гүйцэтгээгүй байхад гүйцэтгэгч “Тэсийн Бүрд” ХХК-д санхүүжилт 7.0 сая төгрөгийг олгосон,

Ховд:

- Дарви сумын сургуулийн дотуур байрыг 2017 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр улсын комиссын гишүүд гүйцэтгэгч “Буянтын боргио” ХХК-д үүрэг, даалгавар өгч ашиглалтад хүлээн авсан хэдий ч үүрэгт ажлыг гүйцэтгээгүй байна.
- Мөн сумын 146.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сургуулийн хичээлийн байрны засварын ажил чанаргүй хийгдсэн, хичээлийн байрны нүүрэн талын будаг ховхорсон цаашид ч ихсэх хандлагатай байна.

2.25 Зарим ТЕЗ нар төсвийн хэмнэлтээс шинээр арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталж, санхүүжүүлсэн нь “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.22¹⁶-т заасныг зөрчсөн байна. Тухайлбал,

- ЭМС-ын багцад шинээр 10,319.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй их засвар, 13,520.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоног, төхөөрөмж батлагдсанд ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу тендер шалгаруулалт явуулж, их засварын төсвөөс 252.9 сая төгрөг, тоног, төхөөрөмжийн төсвөөс 722.9 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гарсныг ЭМС-ын 2017 оны А/418, А/391 дугаар тушаалаар шинээр төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталж, тендерийн хэмнэлтийг зарцуулсан.
- Сангийн сайдын багц, Гаалийн ерөнхий газарт батлагдсан тоног төхөөрөмж худалдан авах 1,400.0 сая төгрөгийн өртөгтэй ажлын тендерийн хэмнэлт 48.9 сая төгрөгөөр 19 ширхэг суурин компьютер, 10 ширхэг принтер худалдан авсан
- Дорноговь аймгийн Сайнишанд сумын 6, 7-р цэцэрлэгийн засварын ажлын зохиогчийн хяналтын зардал 1.4 сая төгрөгийг “Болор аграмба” ХХК-д /7-р цэцэрлэгийн гүйцэтгэгч/ зураг төсөл хийлгүүлэхээр шилжүүлсэн.
- Орхон аймгийн Баян-Өндөр сумын спортын ордны дээвэр засварын ажлыг бөхийн заал болгон өөрчлөн хэрэгжүүлж 77.5 сая төгрөгийг гүйцэтгэгч “Либерти” ХХК-д олгосон зэргээр төсвийн хэмнэлтийг зарцуулж байгаа нь их засвар, тоног төхөөрөмжийн үнийн судалгааг зах зээлийн үнээр хийгээгүй, бодит хэрэгцээ шаардлагад тулгуурлан төлөвлөөгүйтэй холбоотой байна.

2.26 “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.9¹⁷-т заасныг зөрчиж захиалагч байгууллага барилга, их засварын ажил бүрийг биечлэн хянаагүй, захиалагч болон зохиогчийн хяналтыг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлээгүй, хяналтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг эргэж шалгаагүй зэргээс дараах зөрчлүүд гарсан байна. Тухайлбал,

БСШУСС-ын багцад:

- УБ хотын ХУД-ийн 8,000.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Соёлын өвийн төвийн барилгын угсралтын ажлыг 2014 оноос эхлүүлж, техникийн нөхцөл олгогдолгүйгээр ажлыг гүйцэтгэсээр 2017 оны жилийн эцэст ажлын гүйцэтгэл 82.0 хувьд хүрсэн. Цахилгааны техникийн нөхцөлийг 2017.11.22-ны өдрийн 2857/2017,

¹⁶ Хөрөнгө оруулалтын ажлын тендер шалгаруулалтын дүнд бий болсон хэмнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч зарцуулах эрхгүй.

¹⁷ Захиалагч байгууллага төсвийн хөрөнгөөр баригдаж буй барилга, их засварын ажил бүрийг биечлэн хянаж, шалгах үүрэг бүхий хяналтын инженер, хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх компанийг ажиллуулах бөгөөд хяналтын инженер, хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлж буй компани хяналт хийсэн тухай бүр тэмдэглэл үйлдэж, гүйцэтгэгч байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар, түүний биелэлтийн талаар тэмдэглэж ажлын гүйцэтгэлд хавсаргах бөгөөд барилга ашиглалтад орсны дараа санхүүжилтийн материалын хамт захиалагчийн архивт хадгалуулна.



цэвэр, бохир усны техникийн нөхцөлийг 2017.10.11-ний өдрийн 580/17, холбооны 2017.11.10 ТН-В495/2017 нөхцөлөөр олгосон боловч гадна шугам сүлжээний ажил хийгдээгүйгээс ажлыг дуусгах боломжгүй болсон.

- УБ хотын СХД-ийн 640 суудалтай, 104 дүгээр сургуулийн барилгын ажил дуусч, 2017.12.26-ны өдрийн барилга, байгууламж байнгын ашиглалтад оруулах комиссын 2017/586 дугаар актаар хүлээлгэн өгсөн боловч 2018 оны 5 дугаар сарын байдлаар гүйцэтгэгч “Фужуи Алтай” ХХК комиссоос өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй, захиалагч хяналт тавиагүй байна.

ЭМС-ын багцад:

- Эрүүл мэндийн салбарт улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа их засварын ажлын гүйцэтгэлд захиалагчийн техник хяналтын хэрэгжүүлэх хяналтын инженер, хяналтын зөвлөх үйлчилгээг ажиллуулахгүй мэргэжлийн бус хүмүүс үе шатны хяналтыг хийж, ашиглалтад актаар хүлээн авсан.
- Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг солихдоо өмнөх гүйцэтгэгч болох "Лайт капитал хаус" ХХК, "Гуулин тал" ХХК, "Монинжбар" ХХК, "Бэржин-Уньт" ХХК-уудтай гэрээг дүгнэж акт үйлдээгүй, хийсэн ажлын тоо хэмжээг төсөвтэй нь тулгаж илүү төлсөн санхүүжилтийн зөрүүг гаргаж, нэхэмжлэлгүйгээр нийт 5,105.4 сая төгрөгийн гэрээг цуцалсан.

Зураг, төслийг гүйцэтгэгч байгууллага:

- Орхон аймгийн Баян-Өндөр сумын мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны зургийг зохиогч “Асгат өргөө” ХХК ажлын зурагт өрөөний тодорхойлолтыг давхар бүрийн байгуулалтад тодорхойлоогүй, хийц хэрэглээгүүдийг тодорхой заагаагүй, өндөржилтийн талаар тайлбар бэлтгээж оруулаагүй.
- Хэнтий аймгийн Хэрлэн сумын нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын төсөвт өртгийн тооцоололд А, Б блокны тоосгон хамар ханын ажлыг давхардуулан төсөвт өртгийг 744.4 сая төгрөгөөр илүү тооцсон, цахилгаан шат болон угсралтын ажлыг төсөвт тусгаагүй.
- Дархан-Уул аймгийн Дархан сумын 2200 суудалтай спорт цогцолборын барилгын “Идеал групп” ХХК 2010 онд холбогдох норм ба дүрэм, зургийн даалгаврын дагуу боловсруулж, баталгаажуулалт хийлгэсэн боловч спорт заал, усан бассейны агаар сэлгэлт, салхивчийн систем, металл хучилтыг буруу, бассейны технологийн зургийг тодорхойгүй байдлаар төлөвлөснөөс зурагт өөрчлөлт хийх шаардлага үүсэж, 2014-2015 онуудад технологийн зогсолт хийсэн.

2.27 Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журмын 4.21-т "... Төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасныг зөрчиж батлагдсан төсөвт өртгөөс давуулан гэрээ байгуулсан байна. Тухайлбал,

Шадар сайдын багцад:

- Улаанбаатар хотын Багахангай дүүрэгт баригдаж буй аврах, гал унтраах ангийн барилгын 2017 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт өртөг 1,250.0 сая төгрөг, магадлал хийгдсэн төсөвт өртөг 2,089.4 сая төгрөг байхад 1,820.9 сая төгрөгөөр буюу батлагдсан төсөвт өртгөөс 570.9 сая төгрөгөөр давуулан гэрээ байгуулж хэрэгжүүлсэн.

БСШУСС-ын багцад:

- Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Биндэр сум/-ын төсвийн тухай хуульд батлагдсан төсөвт өртөг 2,630.7 сая төгрөг гэрээний дүн 2,826.9 сая төгрөгөөр буюу төсөвт өртгөөс 196.2 сая төгрөгөөр өндөр үнээр гэрээ байгуулсан.

Ажлын гүйцэтгэлийг бодитой хянаагүйгээс хийгээгүй ажлын гүйцэтгэлд санхүүжилт олгосон байна

2.28 Захиалагч, зураг төсөл зохиогч байгууллага барилга угсралтын ажлын явцад тогтмол, үр дүнтэй хяналт хийдэггүй, хяналтаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлтээ эргэж шалгадаггүй, барилгын угсралтын ажлын гүйцэтгэлийг газар дээр нь хэмжилт хийж баталгаажуулдаггүй, гэрээг дүгнэж, үүргээ хугацаанд нь биелүүлээгүй гүйцэтгэгчидтэй хариуцлага тооцдоггүй зэргээс шалтгаалж хийгдээгүй ажлын гүйцэтгэлийг хянаж баталгаажуулан санхүүжилт олгож байгаа нь барилга ашиглалтад орох хугацаа удааширч, хөрөнгө оруулалтын үр ашиг буурах, өртөг нэмэгдэх нэг шалтгаан болж байна.

2.29 Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийг ТЕЗ нар буюу захиалагч байгууллага хэрэгжүүлж ажиллахгүй



агаас барилгын ажлын чанар, ажлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй, хийгээгүй ажлын гүйцэтгэлийг баталгаажуулдаг нийтлэг дутагдал байсаар байна.

2.30 Аудитаар нийт 22 ТАХ-ний ажлын гүйцэтгэлийг шалгахад ажлын тоо хэмжээ бүрээр хянаж баталгаажуулаагүйгээс нийт 13 аж ахуйн нэгжид 4,669.1 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээс илүү олгосон байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 4-өөс харна уу/

2.31 Барилгын тухай хуулийн 37.6¹⁸, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журмын 4.17¹⁹, 6.1²⁰ дэх заалтыг зөрчиж, байнгын ашиглалтад оруулаагүй барилга, байгууламжид үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал,

Шадар сайдын багцад:

- Төв аймгийн Зуунмод сумын 2,726.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Аврах, гал унтраах ангийн барилгыг ашиглалтад оруулах комиссын акт гараагүй байхад 2017 оны 3 дугаар сараас ашиглаж эхэлсэн бөгөөд Төв аймгийн Онцгой байдлын газар нь ОБЕГ-аас ирүүлсэн зарлагын баримтыг үндэслэн барилга байгууламжийг данс бүртгэлд тусгасан байна.

Гадаад харилцааны сайдын багц:


- Ёслол хүндэтгэлийн өргөөний шинэчлэл төсөл буюу Гадаад харилцааны яамны өргөтгөлийн барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссын акт гараагүй байхад ашиглаж эхэлсэн.

Гүйцэтгэгч ажлаа хугацаанд нь гүйцэтгээгүйгээс батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглахын тулд тухайн жилийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулжээ

2.32 Аудитын явцад цуглуулсан нотлох баримтад үндэслэн гүйцэтгэгч ажлаа хугацаанд гүйцэтгээгүйгээс барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 5 ТЕЗ-ийн 25,646.2 сая, зориулалт бусаар зарцуулсан 3 ТЕЗ-ийн 963.6 сая, концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд УАГ-аас гаргасан дүгнэлтийг үндэслэн суутган тооцсон 172.2 сая төгрөгийг хасч, 2017 оны хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийг 90.0 хувьтай гэж 1.8 пунктээр бууруулан үнэллээ. /Дэлгэрэнгүйг хавсралт 5-аас харна уу/

2.33 Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгохоор төлөвлөсөн хуваарь болон санхүүжилт олгосон дүнг, хугацааны дарааллаар харьцуулж үзэхэд санхүүжилтийг төлөвлөсөн хуваарийн дагуу олгоогүйгээс гадна 2017 оны 12 дугаар сард жилд олгох санхүүжилтийн 49.3 хувь буюу 265,988.8 сая төгрөгийг олгосон байна.

Дүрслэл 7. Хөрөнгө оруулалтын батлагдсан санхүүжилт, олголтыг харьцуулсан байдал /сая төгрөг, сар/



Эх сурвалж: УАГ

¹⁸ Дуусаагүй, дууссан боловч ашиглалтад оруулаагүй барилга байгууламжийг ашиглахыг хориглоно.

¹⁹ Захиалагч шинээр баригдсан барилга байгууламж, их засварыг ашиглалтад оруулах комиссын актаар ашиглалтад хүлээн авна.

²⁰ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламжийг барьж дуусах хүртэл, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр захиалагч байгууллага эргэлтийн бус хөрөнгөөр бүртгэн санхүүгийн тайландаа тусгана.



үү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагч нарт хяналт бүрэн тавьж чадахгүй байгаагаас санхүүжилтийн явцад хууль, журам зөрчигдөж байна

2.34 Зарим ТЕЗ-д улсын төсвөөс 2017 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад батлагдаагүй, гэрээний хугацаа дуусч нэмэлт өөрчлөлт хийгдээгүй арга хэмжээнд санхүүжилт олгосон нь Төсвийн тухай хуулийн 10.1.14²¹, 16.5.5²², Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хяналт, санхүүжилт, тайлагналын журам”-ын 4.18 дахь заалтыг зөрчсөн байна. Тухайлбал,

Шадар сайдын багцаас 2017 оны Төсвийн тухай хуулиар хэрэгжилт батлагдаагүй дараах арга хэмжээнд санхүүжилт олгосон:

- Завхан аймгийн Улиастай сумын Аврах, гал унтраах ангийн 2,590.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2016 онд ашиглалтад орсон барилгын ажлын үлдэгдэл санхүүжилтэд 55.9 сая төгрөгийг олгосон.
- УБ хотын СБД-т 2016 онд ашиглалтад оруулсан Онцгой байдлын албаны командын байрны барилга угсралтын ажлын гэрээний хугацаа 2015 онд дууссан ч гэрээнд сунгалт хийгээгүй, 36.7 сая төгрөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй үлдэгдэл санхүүжилтийг 2017 онд олгосон.

Мөн сайдын багцаас ажлын гүйцэтгэлд нь хяналт хийгдсэн 5 барилгын нийт 279.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй, 2 гүйцэтгэгчид нийт 206.4 сая төгрөгийн санхүүжилтийг гэрээний үнийн дүнгээс илүүгээр олгосон:

- Аврах, гал унтраах ангийн Улаанбаатар хотын Багахангай дүүргийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Даяар трэйд” ХХК-д 3.6 сая төгрөг,
- Аврах, гал унтраах ангийн Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын барилгын ажлыг гүйцэтгэгч “Ганзосон констракшн” ХХК-д 19.6 сая төгрөг,
- Аврах, гал унтраах ангийн Дархан-Уул аймгийн Дархан сум дахь барилгын ажлыг гүйцэтгэгч “Бум констракшн” ХХК-д 1.0 сая төгрөг,
- Аврах, гал унтраах ангийн Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь барилгын ажлыг гүйцэтгэгч “АСХС” ХХК-д 253.5 сая төгрөг,
- Аврах, гал унтраах ангийн Төв аймгийн Зуунмод сум дахь барилгын ажлыг гүйцэтгэгч “Би энд Кэй” ХХК-д 1.6 сая төгрөгийг тус тус олгоогүй байна.
- Хэнтий аймгийн Батноров сумын Бэрх тосгонд баригдсан аврах, гал унтраах ангийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Нью конитракин” ХХК-д 203.4 сая төгрөг,
- УБ хотын СБД-т баригдсан Онцгой байдлын албаны командын байрны барилгын ажлыг гүйцэтгэгч “Экологи быюлдинг констракин” ХХК-д 3.0 сая төгрөгийг тус тус илүү олгосон.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын багцад:

- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын конторын барилга /Хөвсгөл, Мөрөн сум/, Хот суурин газрын ус хангамж, гидрогеологийн зураглалын судалгаа /Өвөрхангай, Гучин-Ус сум/-ны өмнөх онд хэрэгжиж дууссан ажлын техник хяналтын зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл болох 2.2 сая төгрөгийг аудитын явцад улсын төсөвт төвлөрүүлээ.

2.35 Түүнчлэн ТЕЗ-д Барилгын тухай хуулийн 14.8²³, хөрөнгө оруулалтын барьцааг бүртгэх, чөлөөлөх ажлын тооцоолол, хяналтыг хангалтгүй хийж ирснээс 6 ААН-ээс 353.2 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг илүү, 15 ААН-ээс 436.2 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг дутуу төвлөрүүлж, 3 ААН-ийн 113.2 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг хугацаанаас нь өмнө чөлөөлж, 910.6 сая төгрөгийн хөрөнгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүй байна. Тухайлбал,

- Дорноговь аймгийн Айраг сумын 320 суудалтай сургуулийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Идэрчандмань” ХХК-аас 55.1 сая, Дэлгэрэх сумын 75 ортой цэцэрлэгийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Баянмарз” ХХК-аас 4.4 сая, Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын спорт заалны барилгын ажлыг гүйцэтгэгч “Дорнын оч” ХХК-аас 16.3 сая, Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын 100 ортой цэцэрлэгийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Унага

²¹ тухайн жилийн төсвийн хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалтад шинэ арга хэмжээ нэмж тусгахгүйгээр, тэдгээрийн гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийх

²² Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

²³ Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламжинд энэ хуулийн 14.3-т заасан хугацаанд гүйцэтгэгчээс хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн тодорхой хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.6-д заасны дагуу зохицуулна.



трэйд” ХХК-аас 8.7 сая, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 2 дугаар сургуулийн спорт заалны барилгын ажлыг гүйцэтгэгч “Виртуалсофт” ХХК-аас 5.8 сая, Улаанбаатар хотын Гандантэгчилэн хийдийн өргөтгөлийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Си Эйч Си” ХХК-аас 262.9 сая, нийт 6 ААН-ээс 353.2 сая төгрөгийг илүү суутгаж гүйцэтгэгч байгууллагад хохирол учруулсан.

- Архангай аймгийн Хангай, Жаргалант, Цэцэрлэг сумдын дотуур байрны барилгын ажлыг гүйцэтгэгч “Өлзийчимэг” ХХК-аас 2.7 сая, Төв аймгийн Зуунмод сумын 5 дугаар багийн 100 ортой цэцэрлэгийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Карголенд” ХХК-аас 7.6 сая, Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын 250 суудалтай соёлын төвийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Тэмээн” ХХК-аас 55.4 сая, Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын 240 суудалтай сургуулийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Хан Атрибут” ХХК-аас 18.3 сая, Байн-Өлгий аймгийн Өлгий сумын 1 дүгээр сургуулийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Ховдын тулга” ХХК-аас 174.9 сая, Дархан-Уул аймгийн сумын Мангирт Хабитат хорооны 100 ортой цэцэрлэгийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Жинсийн орой” ХХК-аас 28.5 сая, УБ хотын ХУД-ийн Хайстайн лавирангийн гол ордныг сэргээн засварлах ажлыг гүйцэтгэгч “Энэрэлт их эрдэнэ” ХХК-аас 16.3 сая, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын 500 суудалтай соёлын төвийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Монре констракин” ХХК-аас 46.8 сая, Төв аймгийн Баянцагаан сумын соёлын төвийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Засагт хаан” ХХК-аас 29.3 сая, Орхон аймгийн Баян-Өндөр сумын 4 дүгээр цэцэрлэгийн барилгын засварын ажлыг гүйцэтгэгч “Хангайн хятруун” ХХК-аас 0.8 сая, Хэнтий аймгийн Батишрээт сумын 320 суудалтай сургуулийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Эрхэт наран” ХХК-аас 3.8 сая, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын усан бассейны барилгын ажлыг гүйцэтгэгч “Жаанар” ХХК-аас 2.4 сая, Дорнод аймгийн Дашибалбар сумын спорт заалны барилгын ажлыг гүйцэтгэгч “Аригун” ХХК-аас 24.8 сая, Сэлэнгэ аймагт цэцэрлэгийн барилга барьсан “Ата трэйд” ХХК-аас 14.8 сая, УБ хотын БГД-ийн 77 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Хархорин өргөө” ХХК-аас 9.8 сая төгрөг, нийт 15 ААН-ийн 436.2 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг дутуу суутган төвлөрүүлсэн.
- Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын 240 суудалтай сургуулийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Хан Атрибут” ХХК-ийн 80.2 сая, Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын 100 ортой дотуур байрны барилгын ажлыг гүйцэтгэгч “Бунбах” ХХК-ийн 4.3 сая, Төв аймгийн Зуунмод сумын 100 ортой цэцэрлэгийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Чин ван констракин” ХХК-ийн 28.7 сая, нийт 113.2 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг хугацаанаас өмнө чөлөөлсөн байна.

Шадар сайдын багцын 7 төсөл, арга хэмжээний 910.6 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг дансанд байршуулаагүй:

- Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Аврах, гал унтраах ангийн 3,245.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга угсралтын ажлыг “Ганзосон констракин” ХХК гүйцэтгэсэн бөгөөд барилгыг 2017.11.17-нд улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн боловч барьцаа 162.3 сая төгрөг,
- Дархан-Уул аймгийн Дархан сумын Аврах, гал унтраах ангийн 3,302.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга угсралтын ажлыг “Бум констракин” ХХК гүйцэтгэсэн бөгөөд барилгыг 2017.11.10-нд улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн боловч барьцаа 165.1 сая төгрөг,
- Сэлэнгэ аймгийн Мандал сумын Аврах, гал унтраах ангийн 3,302.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга угсралтын ажлыг “АСХС” ХХК гүйцэтгэсэн бөгөөд барилгыг 2016.11.21-нд улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн боловч барьцаа 165.1 сая төгрөг,
- Төв аймгийн Зуунмод сумын Аврах, гал унтраах ангийн 2,726.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга угсралтын ажлыг “Би энд Кей” ХХК гүйцэтгэсэн бөгөөд санхүүжилтээ бүрэн авсан боловч барьцаа 136.3 сая төгрөг,
- Хэнтий аймгийн Батноров сумын Бэрх тосгоны Аврах, гал унтраах ангийн 1,905.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга угсралтын ажлыг “Нью констракин” ХХК гүйцэтгэсэн бөгөөд барилгыг 2017.08.23-нд улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн боловч барьцаа 95.3 сая төгрөг,
- УБ хотын СБД-т баригдаж 2016.08.01-ний өдрийн улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн Онцгой байдлын албаны командын байрны 1,140.5 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий ажлыг “Экологи бьолдинг констракин” ХХК гүйцэтгэсэн боловч барьцаа 57.0 сая төгрөг,
- Завхан аймгийн Улиастай сумын Аврах, гал унтраах ангийн 2,590.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга угсралтын ажлыг “Би энд Кей” ХХК гүйцэтгэсэн бөгөөд барилгыг 2017.11.18-нд улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн боловч барьцаа 129.5 сая төгрөгийг тус тус байршуулаагүй байна.

ХХААХҮС-ын багцад:

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилгын чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг ТБОНӨХБАҮХАТХ-ын 43 дугаар зүйлийн 43.6-д заасны дагуу барьцаалж авахгүй байгаа нь төрийн өмчийн чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлийг дагуулж байна.

2.36 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг богино хугацаанд шийдвэрлэх үүднээс зарим ТЕЗ-аас эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг “Төсвийн хөрөнгө



алтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.26²⁴ дахь заалтыг зөрчиж, ТЕЗ-ийн хөрөнгө оруулалтын дансаар дамжуулалтгүй шилжүүлж байгаа нь эрх шилжсэн төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт тавих боломжийг хязгаарласан байна. Тухайлбал,

ЭМС-ын багцад:

- Хөрөнгө оруулалтын 194.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл, арга хэмжээ хэрэгжиж 60.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсоноос нийт санхүүжилтийн 79 хувь буюу 47,990.3 сая төгрөг ТЕЗ-ийн хөрөнгө оруулалтын дансаар дамжсан, 21 хувь буюу 12,833.4 сая төгрөгийг Сангийн яамнаас эрх шилжүүлэн авсан төсөв захирагчийн данс руу шууд шилжүүлсэн байна.
- Худалдан авах ажиллагаа нь зохион байгуулагдаагүй шууд гэрээ байгуулсан Үндэсний оношилгоо эмчилгээний төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч "Одкон холдинг" ХХК-нд шүүхийн шийдвэр гараагүй байхад Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Хөрөнгө шийдвэрлэх тухай" А/516 дугаар тушаалыг үндэслэн Сангийн яамнаас санхүүжилтийн эрхийг нээж, Эрүүл мэндийн яамны барьцаа хөрөнгийн дансанд 1,028.3 сая төгрөгийг байршуулсан.
- Үндэсний оношилгоо эмчилгээний төвийн цогцос хадгалах байрны барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч "Жу Жу" ХХК-нд хийгдээгүй ажилд нь бодит бус гүйцэтгэл баталгаажуулж 744.6 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэн, эрүүл мэндийн яамны барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журмын 4 дүгээр зүйлийн 4.3-т "Захиалагч байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан норм, норматив, дүрэм болон тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын үе шатны ажлын хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж, баталгаажуулна." 4.11-т "Захиалагч барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон барилга угсралт, их засварын ажлын календарчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг мөнгөн дүнгээр илэрхийлсэн байдлаар гаргаж, энэ журмын тавдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргана." гэж заасныг зөрчсөн байна.
- Эрүүл мэндийн яам барьцаа хөрөнгийн дансанд байршуулах ёсгүй 1,773.0 сая төгрөгийн хөрөнгийн зардлыг тус дансанд байршуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 43 дугаар зүйлийн 43.6-д Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах гэж заасныг зөрчсөн байна.

БСШУСС-ын багцад:

- Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Биндэр сум/ төсөл, арга хэмжээний 2017 онд гарсан ажлын гүйцэтгэл 634.3 сая төгрөг байхад БСШУСЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2017 оны №2/12614 дугаар албан бичгийг үндэслэн Төрийн сангаас 789.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь гүйцэтгэлээс 154.7 сая төгрөгөөр илүү байна.
- Сонгинохайрхан дүүргийн 104 дүгээр сургуулийн барилга, гүйцэтгэгч "Фужси Алтай" ХХК-тай ажлын тоо хэмжээ тодорхой бус, төсөвт өртөг баталгаажсаагүй байхад нэмэлт 185.6 сая төгрөгийн гэрээ байгуулж, санхүүжилтийг бүрэн олгосон.

ХХААХҮС-ын багцад:

- Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо техник хяналтын зардлыг гүйцэтгэгчийн данс руу шууд шилжүүлж байгаа нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ын 4.18 дахь заалтыг зөрчсөн байна.

2.37 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, үр нөлөөт байдлыг хангуулах чиглэлээр ҮАГ-аас жил бүр өгч буй зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, алдаа дутагдал давтан гарахаас сэргийлэх чиглэлээр төрийн захиргааны байгууллагууд идэвхи санаачлагагүй ажиллаж байгаа нь дээрх зөрчил, дутагдал давтагдан гарах үндэслэл болж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

²⁴ Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад батлагдсан, эрх шилжүүлж аймаг, нийслэл, сум, дүүрэг худалдан авах ажиллагааг нь зохион байгуулсан төсвийн хөрөнгө оруулалтын ажлын хувьд тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалт, их засварын дансаар дамжин санхүүжилт хийгдэнэ.



наар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна

2.38 УАГ-аас “Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаар Ерөнхий сайдад 3, Сангийн сайдад 3, ТЕЗ-дад 3 зөвлөмж өгөгдсөн байна.

2.39 Зөвлөмжийн биелэлтийг авч үзэхэд 2017 оны сүүлээр УИХ-ын 69, 337 дугаар тогтоол, 2018 онд Засгийн газрын 34 дүгээр тогтоолуудаар ТЕЗ-дад хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, 2018 онд шинээр эхлэх ТАХ-ний төсөвт өртгийг нягтлах, чиглэл үүрэг даалгавар өгсөн, 2018 оны эхний чуулганаар АХБ-наас “Төсвийн ил тод байдлыг сайжруулах” 10 сая ам.долларын зээлийн хэлэлцээрийг УИХ-аар соёрхон батлуулсан, КОЙКА-гийн буцалтгүй тусламжаар “Дунд хугацааны төсвийн төлөвлөлтийг сайжруулах” төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн, ашиглалтгүй орхигдсон барилгуудыг 2018-2019 оны төсөвт тусган хэрэгжүүлж байгаа зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.

2.40 ТЕЗ-даас хөрөнгө оруулалтын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлж ажиллахгүй байгаагаас зөрчил, дутагдал давтан гарсаар байгаа нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, үр ашигт сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал,

- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад зарим ТЕЗ-дын хэрэгжүүлэх арга хэмжээ нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих боломжтой, тухайн ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хамааралгүй арга хэмжээг баталсан нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулах, улсын төсөвт ачаалал үүсгэж байна. Жишээ нь: БХБС-ын багцад шинээр эхлэх арга хэмжээнд нийслэлийн зарим дүүрэг болон зарим аймаг, сумдын хүүхдийн тоглоомын талбайн тохижилт, гудамж талбайн гэрэлтүүлэг, ахмадын чийрэгжүүлэх талбай, автомашины зогсоол, халуун ус, ахуй үйлчилгээний барилга зэрэг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой тухайн салбарт хамааралгүй нийт 8,531.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4,031.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 14 ТАХ-г шинээр хэрэгжүүлэхээр тусгасан байна.
- ХНХС-ын багцад өнгөрсөн 2017 оны их засварын хөрөнгөөс ахмадын амралт, сувиллын газрын барилгын өргөтгөл нэрийн дор ТЕЗ-аас Хөвсгөл, Хэнтий аймагт эрх шилжиж, орон нутгийн Засаг дарга өөрийн эрх мэдлийн хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгөөс нэмэлт хөрөнгө гарган шинэ барилга барьж улмаар тухайн хөрөнгийн дутуу санхүүжилтийг Х.2.1.9-д “Ахмадын амралт, сувиллын газрын барилгын өргөтгөл /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон/”, Х.2.1.8-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хөгжлийн төвийн барилга /Дорнод, Хэрлэн сум/”, 2015 оноос эхлэн хэрэгжиж байсан Баянгол хүүхдийн зуслангийн дутуу санхүүжилтийг “Баянгол хүүхдийн зуслангийн театрын барилга, гадна тохижилт /Улаанбаатар, Налайх дүүрэг/” гэж шинэ арга хэмжээ мэтээр тусган баталсан байна

2.41 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд УАГ-аас хийсэн гүйцэтгэлийн аудитаар 2016 онд 9,823.0 сая төгрөгийн 3 албан шаардлага, 2,269.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосноос 3,500.0 сая төгрөгийн 1 албан шаардлагын хэрэгжилт хангагдаж, 2,269.9 сая төгрөгийн төлбөрийн акт хүчингүй болж, бусад албан шаардлагын хэрэгжилтийг хангаагүй байна.


2.42 Харин 2017 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар 2,333.3 сая төгрөгийн 9 төлбөрийн акт тогтоож, 933.1 сая төгрөгийн 4 актын төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлж, 1384.8 сая төгрөгийн 3 төлбөрийн актыг хүчингүйд тооцсон байна. Нийт 4,766.2 сая төгрөгийн 5 албан шаардлага өгсний үр дүнгээр 2 албан шаардлага хэрэгжиж, 1,974.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн дүн мэдээ гарч байна.

2.43 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2017 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн дээрх аудитаар нийт 81,810.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 146.2 сая төгрөгийн 10 төлбөрийн акт тогтоож, 81,662.5 сая төгрөгийн 54 албан шаардлагыг ТЕЗ нарт хүргүүлэхээр бэлтгээд байна.

**Бүлэг 3.****Хөрөнгө оруулалтын үр дүнг тооцох аргачлал боловсруулж, хэрэгжилт, гүйцэтгэлд тавих дотоод аудитын болон хөндлөнгийн хяналтын тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай байна**

3.1 Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд 2,503.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй нийт 373 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 1,538.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 293 төсөл, арга хэмжээг дуусгахаар байсан байна. Нийт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс дийлэнх буюу дэд бүтцийн салбарт 49.1 хувь, боловсролын салбарт 27.6 хувь нь хэрэгжихээр батлагдсан.

Дүрслэл 8. Хөрөнгө оруулалтын төлөвлөсөн үр дүнг гүйцэтгэлтэй харьцуулсан байдал /тоо/



3.2 ТЕЗ-дын тухайн төсвийн жилд хүрэх зорилтыг тодорхойлон, яамдын ХШҮДАГ-аас дотоод үйл ажиллагаандаа хяналт-үнэлгээ, мониторинг хийж байгаа боловч тухайн салбарт буюу ТЕЗ-дын багцад хамаарах төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлийн байдалд Засгийн газрын 2013 оны 322 дугаар

тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу хяналт хийгдэхгүй байна.

3.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөгөөт хугацаанд бүрэн хэрэгжээгүйгээс шалтгаалан хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн үр дүн төлөвлөснөөс бага байна.

Хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна

3.4 “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 5.3²⁵-д заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тухайн онд төсвийн тухай хуульд батлагдан хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг хийдэг бөгөөд 2017 онд 1 төсөл, арга хэмжээг газар дээр нь очиж шалгасан байна.

3.5 Энэ нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас 2017 онд хэрэгжих төсөл, арга хэмжээнд тавьсан хяналт хангалтгүй, Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журмыг хэрэгжүүлж ажиллахгүй байна.

3.6 Төсвийн тухай хуулийн 16.5.5, “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.5, 4.21-д заасныг тус тус зөрчиж, батлагдсан гүйцэтгэлээс давуулан санхүүжилт олгож байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна. Тухайлбал, МУШС-ын эрхлэх асуудлын хүрээнд ОБЕГ-ын захиалгаар баригдаж ашиглалтад орсон 2 барилгын өртгийг 87.8 сая төгрөгөөр дутуу, 5 барилгын өртгийг 153.7 сая төгрөгөөр илүүгээр хөрөнгийн бүртгэлд тусгасан байна.

²⁵ Сангийн яам төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилтийн зарцуулалтын байдалд хяналт тавьж, шаардлагатай бол барилга байгууламж, их засварын ажилд шалгалт хийж, зөрчил дутагдалыг арилгуулах арга хэмжээ авна. Үүнд хяналт, шалгалт мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулж болно.



Монгол Улсын Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртгийг Санхүүгийн тайланд 153.7 сая төгрөгөөр илүү, 87.8 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн ч авлага, өглөг үүсгээгүй. Олгосон гүйцэтгэлийн санхүүжилтээр бус ажил гүйцэтгэх гэрээний үнийн дүнгээр санхүүгийн тайланд бүртгэжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг төлөвлөх, тооцох эрх зүйн орчинг бүрдүүлээгүй байна

3.8 Олон Улсын Валютын сангаас хийсэн судалгаагаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг чадавхижуулах нь хөрөнгө оруулалтын үр өгөөж, гарцыг нэмэгдүүлдэг²⁶ төдийгүй төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага сайтай улс орнуудын хөрөнгө оруулалтын үр дүн тодорхой, үр нөлөөтэй, бүтээмжтэй байдаг бөгөөд бага орлоготой хөгжиж буй орнууд²⁷ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд оролцож буй субъектуудыг чадавхижуулах замаар төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг дээшлүүлэх боломжтой гэсэн зөвлөмжийг өгсөн байна.

3.9 Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.11²⁸-д зааснаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын нийгэм, эдийн засагт үзүүлэх үр ашиг, үр дүнг тооцох аргачлалыг Сангийн сайд батлах ёстой боловч одоог хүртэл батлагдаагүй, хуулийг хэрэгжүүлээгүй явж ирсэн нь төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна.

3.10 Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь нэг талаасаа хувийн секторыг дэмжин, цаашлаад эдийн засаг болоод нийгмийн үзүүлэлтүүд болох ажилгүйдэл буурах, өрхийн орлого нэмэгдэх, ажлын байр бий болох зэрэг эерэг нөлөө үзүүлж, ДНБ-ний өсөлтийг дэмжихэд чиглэгддэг. Тухайлбал, сүүлийн 5 жилд улсын төсвийн хөрөнгө оруулалт дунджаар 17.5 хувиар, 1 хүнд ногдох ДНБ дунджаар 6.7 хувиар, өрхийн орлого дунджаар 7.4 хувиар тус тус өссөн ч ядуурлын хэмжээ 30.0 хувиас буурахгүй байна.

3.11 Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь 1 хүнд ногдох ДНБ болон өрхийн орлоготой хамаарал багатай²⁹ байгаа нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч нь тогтсон хэсэг бүлэг аж ахуйн нэгжүүд байдаг, 2017 оны байдлаар төсвийн хөрөнгө оруулалтын 27.5 хувь нь боловсрол, эрүүл мэндийн салбарт зарцуулагдаж тус салбарт ажиллагсдын ажлын байрыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлж байгаа ч тэдэнд олгох цалингийн түвшин харьцангуй бага байдаг, мөн төсвийн хөрөнгө оруулалт томоохон хэмжээний орлого олох төсөл, арга хэмжээнд бараг зарцуулагддаггүй зэрэгтэй холбоотой байна.

3.12 Түүнчлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашигт авлига, хээл хахууль сөргөөр нөлөөлдөг гэж үздэг³⁰ бөгөөд манай улсын авлигын индекс өмнөх онтой харьцуулахад 2017 онд 2 пунктээр нэмэгдсэнээр хөрөнгө оруулалтаас хүртэх үр өгөөж тодорхой хэмжээнд буурахад хүргэж, нийт хүртэх 100 хувийн өгөөжөөс 18.1 хувийг³¹ хүртсэн тооцоолол гарч, хангалттай түвшинд хүрээгүй гэдэг нь зэрэгцүүлсэн үзүүлэлтээс харагдаж байна.

Дүрслэл 9. Монгол Улсын сүүлийн 5 жилийн авлигын түвшин

²⁶ "Making public investment more efficient", IMF, June 11, 2015


²⁷ Low-income developing countries

²⁸ Хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үр дүнг тооцох аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

²⁹ Улсын төсвийн хөрөнгө оруулалт 1 хүнд ногдох ДНБ-ний корреляцийн коэффициент: -0.31, Улсын төсвийн хөрөнгө оруулалт өрхийн дундаж орлогын корреляцийн коэффициент: -0.35 байна.

³⁰ Mauro, P6 /1995/. "Corruption and growth, Quarterly Journal of Economics 6 110:681-712" судалгаанд авлига нь хөрөнгө оруулалтын түвшинг бууруулдаг гэж, Mushfiq us Swaleheen /2007/. "Corruption and Investment Choices. KYKLOS, Vol. 60-2007-No. 4, 601-616" судалгаанд улсын хөрөнгө оруулалтад авлига хэрхэн нөлөөлдөг болохыг судалсан судалгаанаас үндэслэсэн математик загвараар Монгол Улсын хөрөнгө оруулалтын өгөөж болон Олон улсын "Транспаренси Интернэшнл" байгууллагаас гаргадаг "Авлигын төсөөллийн индекс"-ийн хоорондын хамаарлыг авч үзсэн ба хоорондоо хүчтэй хамааралтай байна. /корреляцийн коэффициент: 0.66 /t-stat=2.18//

³¹ "Авлигын төсөөллийн индекс"-ийг 100 буюу огт авлигагүй үеийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын өгөөжийг бодит өнөөгийн "Авлигын төсөөллийн индекс" 27-36 байх үеийн хөрөнгө оруулалтын өгөөжтэй харьцууллаа.



Эх сурвалж: Транспэрэнси Интернэшнл Олон Улсын байгууллагаас зарласан авлигын индекс (CPI). 100 байвал авлигагүй гэж үзнэ. www.transparency.org/news/feature/corruption_perceptions_index_2017

3.13 Иймд улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, түүний хөтөлбөрийг эдийн засаг болоод нийгмийн үзүүлэлтүүдэд нөлөөлөхүйц байхаар төлөвлөж, боловсруулж, хэрэгжүүлдэг байх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт хангалтгүй байсан нь хөрөнгө оруулалтын үр дүнд сөргөөр нөлөөлж байна

3.14 ТЭЗ нар төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөхдөө бэлтгэл ажлыг хангалттай хийгээгүй, хөрөнгө оруулалтаас бий болох үр өгөөжийг тооцоогүй, захиалагчийн хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүйгээс шалтгаалан зөвхөн тооцох боломжтой хэсгийн тооцооллыг хийж үзэхэд 5 төслөөс 3,393.1 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг зөрчсөн байна. Үүнд:

- ХНХС-ын захиалгаар баригдсан УБ хотын СБД-ийн Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөхдөө газрын зөвшөөрлийг аваагүйгээс газрын байрилыг 2 удаа сольсноос шалтгаалж гарсан талбай цэвэрлэх, хашиа барих, газар шорооны ажлын 29.0 сая төгрөгийг магадлашгүй ажлын зардлаар тооцож, санхүүжилтийг олгосон байна.
- ГХЯ-ны Ёслол хүндэтгэлийн өргөөний барилгын зураг, төсвийн өөрчлөлтөд магадлал хийлгээс баталгаажуулалгүйгээр барилгын ажлыг үргэлжлүүлж гүйцэтгүүлснээс 91.8 сая төгрөгийн ажлыг чанаргүй хийснийг давхардуулан хийж үргүй зардал гаргасан.
- БХБС-ын багцад Сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдсан 960 суудалтай сургуулийн барилгын угсралтын ажлыг гүйцэтгэх явцад "Барилга байгууламж" ХХК-ийн зургийн алдаанаас шалтгаалж В блокны спорт заалны дээвэр багана буулгаж, 1м бетон багана нэмж дахин угсралт хийснээс 45.4 сая төгрөгийн үргүй зардал гаргасан.
- ХЗДХС-ын багцад хэрэгжсэн Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн барилга /УБ, ЧД/ арга хэмжээг Засгийн газрын 2012 оны 122 дугаар тогтоолоор конторын барилга болгох шийдвэр гаргасан, мөн 2016 оны 323 дугаар тогтоолоор эргээд эмнэлгийн барилга барих шийдвэр гаргаснаас 2,726.9 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан.
- Төрөх эмнэлэг 50 ор /Дорноговь, Сайншанд/ төслийн гүйцэтгэгч "Монинжбар" ХХК солигдож, "Баярсконстракин" ХХК сонгогдсон боловч "Монинжбар" ХХК барилгын ажлыг гүйцэтгэхдээ 2014 оны 11 сард буюу хүйтний улиралд цутгалт хийснээс хөлдөж 1, 2 дугаар давхрын карказ, хучилт, цутгамал шат үйрч байсан тул буулгуулж дахин шинээр цутгалтын ажлыг хийж улсын төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна. Мөн барилгыг буулгаад шинээр 1, 2 дугаар давхрын угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн боловч 2, 3 дугаар давхарын төмөр бетон карказын бетон хөлдөлттэй, багана, дам нуруу, хучилтыг тасалж цутгасан, гадна дүүргэлтийн ханын өрлөг нь анкер, деталгүй өрлөгийн сетка байхгүй, төмөр бетоны марк нь М250 маркыг хангахгүй дөнгөж 21.7-85.9 марктай, хучилтын зузаан 150 мм-т хүрэхгүй, зоорийн давхрын гадна хана 500 мм-ийн зузаантай бетон байсныг 300 мм-ийн зузаантай цутгаж батлагдсан зураг төсөл, техникийн шаардлагыг хангаагүй байна. "Баярсконстракин" ХХК 2017 оны 9 дүгээр сард барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэхийн өмнө хараат бус, хөндлөнгийн байгууллагаар барилгын ажлын чанарт үзлэг, шалгалт хийлгэхэд цутгамал төмөр бетон хийцүүдийн марк зураг төсөлд тусгагдсан хэмжээнд хүрэхгүй, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэт бага үзүүлэлттэй, 3 дугаар давхрын хучилтан дээр хүн явахад хотолзож, чичиргээ өгч байгаа нь барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй болж 2, 3 дугаар давхрыг дахин буулгахаар болж улсын төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашиггүй болгосон байна.



МЯ, Засгийн газрын 2016 оны 38 дугаар тогтоолд “2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс өмнө гэрээ байгуулсан боловч худалдан авалт нь эхлээгүй арга хэмжээний санхүүжилтийг зохих журмын дагуу зогсоох” гэж заасныг зөрчиж, гүйцэтгэгч “Си Ай Ти” компанитай байгуулсан Хавдар судлалын үндэсний төвийн сити томографийн аппарат нийлүүлэх гэрээг түдгэлзүүлснээр гүйцэтгэгч тоног төхөөрөмжийг захиалгыг хийж баталгаажуулсан, хугацаа алдаж дараа оны төсөвт хөрөнгө төлөвлөгдсөнөөс ханшийн зөрүүгээр улсын төсвөөс 500.0 сая төгрөгийн үргүй зардал гаргасан.

Хүснэгт 8. Аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээний судалгаа

/тоо, хувь, сая төгрөг/

3.15 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 2017 онд хүчин төгөлдөр үйлчилсэн нийт 756 гэрээг ангилж харвал, 3 ба түүнээс дээш тендерт шалгарч гэрээ байгуулсан 66 аж ахуйн нэгж байна.

Нэг аж ахуйн нэгжид ногдож буй гэрээний тоо	ТАХ-ний тоо	ААН-ийн		Гэрээний	
		Тоо	Эзлэх хувь	Нийт дүн	Эзлэх хувь
1	563	563	74.5	925,716.7	56.1
2	254	127	16.8	333,114.1	20.2
3	132	44	5.8	151,470.4	9.2
4	40	10	1.3	123,023.9	7.5
5	35	7	0.9	72,137.6	4.4
6	12	2	0.3	5,342.8	0.3
7	14	2	0.3	30,821.8	1.9
8	8	1	0.1	9,660.1	0.6
НИЙТ ДҮН	1058	756	100.0	1,651,287.4	100.0

Эх сурвалж: УАГ


3.16 Аж ахуйн нэгжүүд боловсон хүчин, хөрөнгө санхүүгийн нөөцөөр хангагдсан хэдий ч жилд 2-оос дээш арга хэмжээг нэгэн зэрэг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй бөгөөд зарим аж ахуйн нэгжүүд 6 хүртэл барилга, байгууламжийн ажлыг гүйцэтгэж байгаа нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, төлөвлөсөн хугацаанд үр дүнгээ өгөхгүй байхаас гадна хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна. Тухайлбал,

- “Монгол дайван” ХХК-ийн байгуулсан 2011 оны 1, 2013 оны 1, 2014 оны 5, нийт 30,170.2 сая төгрөгийн үнийн дүн бүхий 7 гэрээ хугацаандаа хэрэгжээгүйгээс 2017 оны Төсвийн тухай хуулиар дахин хөрөнгө батлагдсан,
- “Жам” ХХК-ийн ЭХС-ын багцын 2015 онд байгуулсан 1, 2017 онд шинээр байгуулсан 2, БСШУСС-ын багцын 2017 онд шинээр байгуулсан 3, нийт 1,872.3 сая төгрөгийн 6 гэрээ,
- “Си Ай Ти” ХХК-ийн 2017 онд шинээр ЭМС-ын багцад 5, ХЗДХС-ын багцад 1, нийт 3,382.0 сая төгрөгийн 6 гэрээ байгуулсан,
- “Сан” ХХК-ийн 2014 онд байгуулсан БХБС-ын багцын 3, 2016 оны 1, ЭХС-ын багцын 2017 онд байгуулсан 1, нийт 41,616.1 сая төгрөгийн 5 гэрээний хэрэгжилтийн санхүүжилтэд 2017 онд хөрөнгө батлагдсан,
- “Альянс тех” ХХК-ийн байгуулсан БХБС-ын багцын 2014 оны 1, 2017 оны 1, ЭХС-ын багцын 2014 оны 1, 2015 оны 1, 2017 оны 1, нийт 15,972.6 сая төгрөгийн 5 гэрээт ажилд мөн л хөрөнгө батлагдсан зэргийг дурдаж болохоор байна.

Зарим салбарт оруулсан хөрөнгө оруулалт үр өгөөжөө өгч байна

3.17 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар боловсролын салбарт 2017 онд ашиглалтад орсон сургуулиудад суралцагсдын тоог өмнөх онд суралцагсдын тоотой харьцуулахад орон нутагт суралцагсдын тоо өмнөх онуудаас буурч байгаа нь дотоодын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой бол нийслэлийн сургуулиудыг өргөтгөн шинэчлэх ажил хийгдсэнээр суралцагсдын тоо өсөж, 3 ээлжээр хичээллэдэг сургуулиудын тоо өмнөх онтой харьцуулахад 38 бүлгээр буурсан үзүүлэлттэй гарсан нь хүн амын нягтаршил ихтэй нийслэл хотод сургуулийн барилга цаашид эрэлттэй хэвээр байгааг илтгэж байна.

Дүрслэл 10. 2017 онд ашиглалтад орсон сургуульд хамрагдагсдын судалгаа /суралцагсдын тоо/



Эх сурвалж: Боловсролын статистик мэдээ

3.18 Энэ нь нийгмийн салбарт оруулсан хөрөнгө оруулалт үр өгөөжөө өгч эхэлж байгааг харуулж байна.

3.19 ТЭЗ-даас дээрхийн адилаар салбаруудын онцлогт тохирсон хөрөнгө оруулалтын дунд болон урт хугацааны үр дүнг тоон болон чанарын үзүүлэлтээр тооцох аргачлал, арга зүйг төсвийн тухай хууль болон холбогдох бусад зохицуулалт, нийгмийн шаардлагын дагуу батлан мөрдүүлж, үр нөлөөг тооцож ажиллах шаардлагатай байна.

Тайлангийн төсөлд ирүүлсэн санал:



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018.06.12 № 9/3746

танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
С.ОЮУНБИЛЭГ ТАНАА

Тайлбар 1-ийг
үзнэ үү.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад Төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгөх зөвлөмж хэсэгт дараах саналыг нэмж тусгахаар хүргүүлж байна.

1.Олон улсын валютын сангаас хэрэгжүүлсэн "Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээ, дүн шинжилгээ"-ний тайлангийн хүрээнд өгсөн зөвлөмжийн дагуу ирэх жилүүдэд шаардлагагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх, шилжиж буй төсөл, арга хэмжээг нэн тэргүүнд тусган, барилга байгууламжийн ашиглалтын хугацааг уртасгах зорилгоор их засварын ажлын төлөвлөлтөд түлхүү анхаарах;

Тайлбар 2-ыг
үзнэ үү.

2.Төсвийн ерөнхийлөн захирагч нар шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад анхаарч, тодорхой зарчим баримтлан тухайн аж ахуйн нэгжтэй гурваас дээш ажил гүйцэтгэх гэрээ байгуулахгүй байхад хяналт тавьж, төслийн хэрэгжих хугацаа, барилга байгууламжийн чанар, хөрөнгө оруулалтын үр ашигт хэрхэн нөлөөлж байгаад анхаарах;

Тайлан хэсэгт дараах саналын дагуу өөрчлөлт оруулах саналтай байна.
Үүнд:

Тайлбар 3-ыг
үзнэ үү.

1. Тайлангийн 1.10 заалт: 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Барилга, хот байгуулалтын сайдын багцад нийт 484,012.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 81,294.1 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 67 төсөл, арга хэмжээ батлагдсан. 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 477,699.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 73,811.3 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 66 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр бууруулан батлагдсан тул тухайн заалтаас хасах;

Тайлбар 4-ийг
үзнэ үү.

2. Тайлангийн 1.18 заалт: Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан XI.1.32. Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 г, д Ø 800-ийн гол шугамыг Ø 1000 мм голчтой болгон өргөтгөх зураг төсөл, барилга угсралтын ажил /1 дүгээр хорооллын урд талаас баруун 4 замын уулзвар хүртэл, Павильон 19-өөс 3/11 холбоос хүртэл 3.4 км/ төсөл, арга хэмжээ нь төсвийн ерөнхийлөн захирагч буюу БХБС-аас ирүүлсэн 2015 онд экспертизээр батлагдсан зураг төсвийг /24,949,206.3 мянган төгрөг/ үндэслэн батлагдсан тул тухайн заалтаас хасах;

0 5374



1 айлбар
үзнэ үү.

5-ыг

3. Тайлангийн 1.24 заалт: БХБС-ын багцад СХД-ийн 5,6 дугаар хороо, Ханын материал орчмын гэр хорооллын цэвэр усны 1466 метр шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил /УБ, СХД/ хэрэгжих хугацаа /2014-2017/ төсөл, арга хэмжээний газрын зөвшөөрөл, барилга байгууламжийн холбогдох техникийн нөхцөл гарч 2017 онд ашиглалтад орсон тул тухайн заалтаас хасах;

Тайлбар
үзнэ үү.

6-г

Тайлангийн дүгнэлт хэсэгт:


1. Дүгнэлтийн 11: “Хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үр дүнг тооцох аргачлалыг баталж мөрдүүлээгүй байна” гэснийг “Хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үр дүнг тооцох аргачлалыг Дэлхийн банкны “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх” төслийн хүрээнд 2018 онд боловсруулан батлуулахаар ажиллаж байгаа нь давуу талтай байна” гэж өөрчлөх;

Дээрх саналыг тайланд тусгахыг хүсье.

Хүндэтгэсэн,

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ХӨГЖЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ГАЗРЫН
ДАРГА

И.БАТХҮҮ





Саналд өгсөн тайлбар:

Тайлбар 1. Саналыг хүлээн авч зөвлөмжийн хэсэгт өөрчлөлт оруулсан.

Тайлбар 2. Саналыг хүлээн авч зөвлөмжийн хэсэгт өөрчлөлт оруулсан.

Тайлбар 3. Саналыг хүлээн авч тайлангийн төслийн холбогдох хэсэгт хасалт хийсэн.

Тайлбар 4. Хөндлөнгийн шинжээчийн дүгнэлтээр баталгаажсан тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.

Тайлбар 5. Саналыг хүлээн авч тайлангийн төслийн холбогдох хэсэгт хасалт хийсэн.

Тайлбар 6. Аудитын хамрах хүрээнд ороогүй тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.



ИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт жил бүрийн төсөв, санхүүгийн эх үүсвэр, улсын төсвийн төлөвлөлттэй уялдуулан тодотгол хийгээгүй байна.
2. ТЕЗ нар хөрөнгө оруулалтын төслүүдийг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 29.4 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаагүй, зураг төсөв нь баталгаажаагүй, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл авагдаагүй, хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүй, бэлтгэл хангагдаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөөр байна.
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд нийт 388 төсөл, арга хэмжээнд 779.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас 351 төсөл, арга хэмжээнд 704.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, гүйцэтгэл 90.3 хувьтай, нийт төсөл, арга хэмжээний 80.7 хувь буюу 313 нь бүрэн хэрэгжиж, 38 нь хэрэгжилт дутуу, 37 нь хэрэгжээгүй байна.
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд 10,340 суудалтай 18 сургуулийн барилга, өргөтгөл, 500 ортой 4 дотуур байр, 3570 ортой 32 цэцэрлэг, МСҮТ-ийн 130 суудалтай хичээлийн байр, 400 ортой дотуур байр, 110 ортой 8 хүн эмнэлэг, эмнэлгийн өргөтгөл, 65.3 км 3 чиглэлийн ЦДАШ, 4 дэд станц, 572.2 км автозам, 437.2 у/м төмөр бетон гүүр, 25 км бохир усны шугам, харин концессын барих-шилжүүлэх төрлөөр 4600 суудалтай 4 сургууль, 725 ортой хүүхдийн цэцэрлэг, 272.6 км автозам, 72.4 у/м гүүр тус тус ашиглалтад оруулсан байна.
5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, гүйцэтгэлийн талаар олон нийтэд мэдээлэх, ил тод байдлыг хангах шаардлагыг бүрэн хэрэгжүүлдэггүй, тендерийн бичиг баримт боловсруулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа худалдан авах ажиллагааны тухай хуулийг баримтлаагүй, хэрэгжилттэй холбоотой баримт материалыг бүрэн бүрдүүлээгүй байх зөрчил давтагдан гарсан хэвээр байна.
6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга байгууламжийн угсралтын ажлын үе шат бүрт мэргэжлийн болон захиалагчийн хяналтын тогтолцооны үр нөлөө хангалтгүй байгаа нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт, барилга байгууламжийн чанар, гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлсээр байна.
7. Сангийн яам, салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллагууд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөх, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, хянаж баталгаажуулах, техникийн нөхцөлөөр хангах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих зэрэг хөрөнгө оруулалтын бүх үе шатанд дотоод аудитын хяналт үйлчлэхгүй байна.
8. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалт, зураг төсөл, төсөв, магадлалын ерөнхий дүгнэлт, барилга угсралтын ажлын гүйцэтгэлтэй холбоотой баримт бичиг дутуу, иж бүрдэлгүй, эмх цэгцгүй, архивын нэгжийн бүрдүүлэлт хийгдээгүй нийтлэг дутагдал оршсоор байна.
9. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, үр нөлөөг хангахад чиглүүлсэн, алдаа дутагдал давтан гарахаас сэргийлж, арилгах чиглэлээр өгөгдсөн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар төрийн захиргааны байгууллагууд идэвхи санаачлагагүй ажиллаж байгаа нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.
10. Хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үр дүнг тооцох аргачлалыг баталж мөрдүүлээгүй байна.



. Салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллагууд улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөж, үр дүнг тооцож ажиллахгүй байна.



ИТЫН ЗӨВЛӨМЖ:

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны анхааралд толилуулах нь:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд илэрч байгаа зөрчил, дутагдал жил бүр давтагдаж, тэдгээрийг арилгах чиглэлээр өгөгдсөн аудитын дүгнэлт, зөвлөмж хэрэгжихгүй байгаад анхаарлаа хандуулна уу.

Монгол Улсын Ерөнхий сайдад:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд оршиж байгаа зөрчил, дутагдал жил бүр давтагдаж, тэдгээрийг арилгах чиглэлээр өгөгдсөн аудитын дүгнэлт зөвлөмжүүд хэрэгжихгүй байгаад анхаарал хандуулж, төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг хянан үзэж, зөвлөмжийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын үр нөлөөтэй арга хэмжээ, авч хэрэгжүүлэх;
- Хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө шаардлага хангасан төсөл, арга хэмжээг тусгах, барилга байгууламжийн гүйцэтгэлийг сонгон шалгаруулалтын бэлтгэл ажил, гэрээ байгуулахад зарцуулах хугацааг богиносгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлэх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд төрийн байгууллагуудын дотоод аудитын оролцоог сайжруулах болон бусад хөндлөнгийн ил тод, мэдээллийн цахим хяналтын тогтолцоог нэвтрүүлэх.

Сангийн сайдад:

- Төсвийн ерөнхийлөн захирагчдын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналд хийх дүн шинжилгээний үр нөлөөг сайжруулах, хуульд заасан хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг хүргүүлж байх;
- Төсвийн ерөнхийлөн захирагчид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж буй барилга, байгууламжийн ажлын гүйцэтгэлийг бодит ажлын гүйцэтгэлтэй нийцүүлэн баталгаажуулж чадахгүй байгаагаас хийгдээгүй ажлын гүйцэтгэлд санхүүжилт олгогдох, барьцаа хөрөнгийг бүрэн төвлөрүүлээгүй байх нөхцөл үүсэж байгаа тул барилга, угсралтын ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, газар дээр нь биет үзлэг хийж байх.
- Хөрөнгө оруулалтын хэрэгжилт, түүний үр дүнд бий болсон хөрөнгөд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах талаар зохих арга хэмжээ авч, орон нутгийн төсвийн байгууллагуудыг арга зүйгээр хангаж ажиллах.

Барилга, хот байгуулалт, Зам, тээврийн хөгжил, Эрчим хүчний сайд нарт:

- Улсын төсвөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зураг төслийн чанар, төсөв зохиох, хянаж баталгаажуулах, зохиогчийн болон зөвлөх үйлчилгээ, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа эрх бүхий хуулийн этгээдийн ажлын хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийгмийн шинж чанартай төсөл, арга хэмжээ, эрчим хүч, автозамын барилга, байгууламжийг иж бүрнээр нь буюу инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн асуудал нь бүрэн шийдэгдсэн байдлаар нийт өртгөөр төсвийн



тухай хуульд батлуулж, хэрэгжилтийг нь нормативт хугацаанд багтаан хэрэгжүүлж дуусгадаг байхаар төлөвлөж, хэрэгжүүлэх санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

- Улсын төсвөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний техникийн нөхцөл олгох, геодезийн дүгнэлт гаргах үйл ажиллагааны шуурхай байдлыг хангуулж, барилга, байгууламжийн угсралтын ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд үйлчилдэг байхаар бодлого, зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
- Гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй, барилга байгууламжийн ажлыг дутуу орхисон, аж ахуйн нэгжид хариуцлага хүлээлгэх, дахин улсын төсвийн хөрөнгийг үргүйдүүлэх асуудлаас урьдчилан сэргийлэх бодлого, зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын салбар тус бүрийн эрх зүйн орчны төлөв байдалд үнэлгээ дүгнэлт өгөх, дотоодын гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн хүчин чадал, нөөц, техник технологийн нэвтрүүлэлт, барилга байгууламжуудын чанар, аюулгүй байдалд судалгаа хийж, үр дүнг мэдээлэх;

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

- Улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжиж эхлэх, ашиглалтад оруулах хугацаа, санхүүжилтийн хэрэгцээ шаардлагыг оновчтой, зөв тооцож төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах үе шатны ажлын явц, барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хяналтыг бүрэн хэрэгжүүлж, ажлын гүйцэтгэлийг ажлын тоо хэмжээ бүрээр газар дээр нь хэмжилт хийж баталгаажуулж байх;
- Ажлын гүйцэтгэлийг зураг, төсөвтэй тулган шалгаж, гүйцэтгээгүй ажлыг заавал хийлгэх, захиалагчийн хяналтыг сайжруулах, ашиглалтын явцад үүссэн гэмтлийг гүйцэтгэгчээр засварлуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж ашиглалтад оруулсан хөрөнгийг анхан шатны баримтаар тулган шалгаж ашиглагч байгууллагын бүртгэл тайланд тусгуулах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах,
- Төсвийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах чиглэлээр шинээр хэрэгжүүлэхээс илүүтэй засварлах, шинэчлэн сайжруулах арга хэмжээг авч хөрөнгийн насжилтыг уртасгах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй барилга, байгууламжийн барилга угсралтын ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд бүрдүүлэх баримт бичгийг иж бүрэн бүрдүүлж, архивын нэгж үүсгэн хадгалах;
- Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, чанаргүй барилга байгууламж барьж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын гэрээг цуцалж, хохирлыг барагдуулан хар жагсаалтад оруулж, хариуцлага тооцох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хууль дүрмийн хүрээнд зохион байгуулаагүй, хариуцлагагүй ажилласан албан тушаалтанд хариуцлага тооцох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлж, дүнг тайлагнах.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/142

Улаанбаатар хот

Г Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.39 дэх заалт, 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Засгийн Газар, Сангийн яаманд тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчдаар арилгуулах, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /У.Хүрэлсүх/-д зөвлөсүгэй.
5. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор /М.Давааням/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР



Монгол Улсын Ерөнхий
аудиторын 2018 оны 06 дугаар
сарын 22-ны өдрийн 19/...
дугаар тушаалын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН 2017 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГТ
ХИЙСЭН АУДИТААР ТОГТООСОН ТӨЛБӨРИЙН АКТ, ӨГСӨН АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

д/д	Төлбөр хариуцагч байгууллага	Дугаар		Тогтоосон ажилтан	Төлбөр зөрчлийн товч утга	Актын төлбөрийн дүн /сая.төгрөгөөр/	Албан шаардлагын төлбөрийн дүн /сая.төгрөгөөр/
		Төлбөрийн акт	Албан шаардлага				
1	Онцгой байдлын ерөнхий газар	01/92		Аудитор Б.Булган	Гэрээний үнийн дүнгээс илүү олгосон санхүүжилтийг буцаан төвлөрүүлэх	21.6	
2	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	01/93		Аудитор Б.Хаш-Эрдэнэ	Барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч компанид захиалагчийн техник хяналтын зардлын санхүүжилт олгосон	2.7	
3	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	01/94		Аудитор Ц.Цолмон	Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг бичихдээ зарим ажлын зардлыг давхцуулан бичсэн	4.0	
4	Хууль зүй, дотоод хэргийн яам	01/95		Ахлах аудитор Б.Саруул, Аудитор Б.Лхагвацэрэн	Захиалагч материалын үнийн зөрүүг тушаал шийдвэргүйгээр гүйцэтгэгч байгууллагатай акт үйлдэж санхүүжилт олгосон	4.96	
5	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	01/96		Аудитор Б.Лхагвацэрэн	Гүйцэтгэгч хийгдээгүй ажилд гүйцэтгэл бичиж санхүүжилт авсан	48.3	
6	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	01/97		Ахлах аудитор Б.Саруул, Аудитор Б.Лхагвацэрэн	Сонгинохайрхан дүүрэг, 104 дүгээр сургуулийн барилга угсралтын ажлын өртгийг давхардуулан гүйцэтгэл бичиж, санхүүжилт авсан	28.6	
7	Зам тээвэр, хөгжлийн яам		01/206	Аудитор М.Доржмаа, Ж.Ганчимэг	Хугацаанд нь хэрэгжүүлээгүй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг 2018.12.01-ний дотор хэрэгжүүлэх		
8	Зам тээвэр, хөгжлийн яам		01/207	Аудитор М.Доржмаа, Ж.Ганчимэг	Дорноговь аймгийн Өргөн сум хүртэлх 18.25 км автозамын ажлыг гүйцэтгэгч "Шинэ хөгжил зам" ХХК-тай асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах, гүйцэтгээгүй ажилд гэрээнд заасны дагуу хариуцлага тооцох		
9	Зам тээвэр, хөгжлийн яам		01/208	Аудитор М.Доржмаа, Ж.Ганчимэг	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 27 км автозамын ажлыг гүйцэтгэгч "Хансуун зам" ХХК-аар гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулах		
10	Эрүүл мэндийн сайд		01/103	Аудитор Б.Хаш-Эрдэнэ	Хяналтын төсөвт өртгөөс давуулан гэрээ байгуулсан ажлын гэрээний дүнг бууруулах		400.8
11	Эрүүл мэндийн сайд		01/205	Аудитор Б.Хаш-Эрдэнэ	Зөрчил арилгуулах тухай		744.7
12	Эрүүл мэндийн сайд		01/204	Аудитор Б.Хаш-Эрдэнэ	Зөрчил арилгуулах тухай		
13	Эрүүл мэндийн сайд		01/104	Аудитор Б.Хаш-Эрдэнэ	Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч солигдсон боловч өмнөх гүйцэтгэгчтэй гэрээг дүгнэж акт үйлдээгүй, хийсэн ажлын тоо хэмжээг төсөвтэй нь тулгаж илүү төлсөн санхүүжилтийн зөрүүг гаргаж, нэхэмжлээгүй		2,890.9
14	Монгол Улсын Ерөнхий сайд		01/219	Аудитор Б.Хаш-Эрдэнэ	Сахилгын шийтгэл ногдуулах тухай		730.0



15	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	01/226	Аудитор Ц.Цолмон	Захиалагчийн хяналт давхардсан, баталгаажгаагүй зураг төсвөөр барилга угсралтын ажил гүйцэтгэсэн зөрчил арилгуулах тухай		
16	Барилга, хот байгуулалтын яам	01/227	Аудитор Ц.Цолмон, Х.Энх-Амгалан	Хариуцлага тооцох тухай		
17	Эрчим хүчний сайд	01/203	Аудитор Ж.Ганчимэг, Д.Даваа-Эрдэнэ	Гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулах, хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах, хариуцлага тооцуулах		
18	Онцгой байдлын ерөнхий газар	01/228	Аудитор Б.Булган	Байнгын ашиглалтад хүлээн аваагүй барилгыг ашигласан зөрчлийг арилгуулах		2,726.1
19	Онцгой байдлын ерөнхий газар	01/229	Аудитор Б.Булган	Санхүүжилтэд батлагдсан хөрөнгөөс илүү дүнгээр санхүүжилт олгосон, техник хяналтын зардлыг санхүүжилтэд олгосон		502.4
20	Онцгой байдлын ерөнхий газар	01/230	Аудитор Б.Булган	Барьцаа хөрөнгийг байршуулаагүй		910.6
21	Онцгой байдлын ерөнхий газар	01/231	Аудитор Б.Булган	Төсвийн тухай хуулиар хэрэгжүүлэхээр батлаагүй арга хэмжээнд санхүүжилт олгосон		55.9
22	Онцгой байдлын ерөнхий газар	01/232	Аудитор Б.Булган	Хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон барилга байгууламжийн өртгийг санхүүгийн тайланд 153.7 сая төгрөгөөр илүү, 87.8 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн		241.5
23	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	01/233	Аудитор Б.Булган	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд төсөл, арга хэмжээний барьцаа хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу байршуулаагүй байна		973.9
24	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	01/234	Аудитор Б.Лхагвацэрэн	Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн яамны хөрөнгө оруулалтын данснаас барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлэн байршуулсан		1,073.5
25	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	01/235	Аудитор Б.Лхагвацэрэн	Төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг яамны хөрөнгө оруулалтын данснаас барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлэн байршуулсан		2,937.5
26	Барилга, хот байгуулалтын яам	01/236	Аудитор Ц.Цолмон, Х.Энх-Амгалан	Дулааны шугамын барилга угсралтын ажлын төсөвт өртөгт нөлөөлөхүйц гол нэрийн материалын үнийг тооцохдоо зах зээлийн үнээс өндөр үнээр авсан		3,419.7
27	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	01/237	Ахлах аудитор Б.Саруул, Аудитор Б.Лхагвацэрэн	Налайх дүүрэгт баригдаж буй спорт цогцолбор барилгын гүйцэтгэгч хийгдээгүй ажилд гүйцэтгэл бичиж санхүүжсэн		245.8
28	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	01/238	Ахлах аудитор Б.Саруул, Аудитор Б.Лхагвацэрэн	Хан-Уул дүүрэг, Соёлын өвийн төв барилгын гүйцэтгэгч хийгдээгүй ажилд гүйцэтгэл бичиж санхүүжилт авсан		908.0
29	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	01/239	Ахлах аудитор Б.Саруул, Аудитор Б.Лхагвацэрэн	Хэнтий аймаг, Хан-Хэнтий чуулгын барилга угсралтын ажлын өртгийг давхардуулан гүйцэтгэл бичиж, санхүүжилт авсан		890.3
30	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	01/240	Ахлах аудитор Б.Саруул, Аудитор Б.Лхагвацэрэн	Архангай аймаг, Хөгжимт жүжгийн театр, гүйцэтгэгч хийгдээгүй ажил болон ажлыг давхардуулан гүйцэтгэл бичиж санхүүжилт авсан		402.3



31	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам		01/241	Ахлах аудитор Б.Саруул, Аудитор Б.Лхагвацэрэн	Сүхбаатар дүүрэг, Үндэсний номын сангийн барилгын төсөвт НӨАТ, нормчлолын сан, захиалагчийн хяналт, магадлашгүй ажлын зардлыг илүү төлөвлөсөн		8.7
32	Батлан хамгаалах яам		01/242	Ахлах аудитор Б.Саруул, Аудитор Б.Хаш-Эрдэнэ	Баянзүрх дүүрэг, Цэргийн эмнэлгийн төв цогцолбор, "БХАҮН" ТӨААТҮГ нь захиалагч, гүйцэтгэгч байгууллагын хооронд санхүүжилтийг дамжуулан өгч ашиг олсон		91.3
33	Батлан хамгаалах яам		01/243	Ахлах аудитор Б.Саруул, Аудитор Б.Хаш-Эрдэнэ	Өмнөговь аймаг, Даланзадгад сум, Говийн бүсийн сургалтын төвийн гүйцэтгэгч хийгдээгүй ажилд гүйцэтгэл бичиж санхүүжилт авсан		590.4
НИЙТ ДҮН						110.2	20,744.3

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2017 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН
ӨРТӨГ НЭМЭГДСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА

/сая төгрөг/

№	Хуулийн код	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг		Зөрүү	
				Эхлэх	Дуусах	2016 он	2017 он	Мөнгөн дүн	Хувь
1	III.3.1.1	МУШС	Алтанбулаг чөлөөт бүсийн Сүхбаатар-Сэлэнгийн 25 км бохир усны шугам хоолойн ажил /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	2012	2017	1,379.8	7,220.0	5,840.2	423.3
2	VI.1.1	ГХС	Гадаад харилцааны яамны Ёслол хүндэтгэлийн өргөөний шинэчлэл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2013	2017	4,460.0	5,160.0	700.0	15.7
3	IX.1.1.1	ХНХС	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Дорнод, Хэрлэн сум/	2013	2017	4,149.0	5,102.4	953.4	23.0
4	IX.1.1.3	ХНХС	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байр /Орхон, Баян-Өндөр сум/	2013	2017	2,247.2	3,473.9	1,226.7	54.6
5	IX.2.1.1	ХНХС	Усан спортын цогцолбор /Улаанбаатар, Сонгинохайрхан, Найрамдал зуслан/	2014	2019	7,550.0	9,600.0	2,050.0	27.2
6	IX.2.1.2	ХНХС	Ахмадын ордны барилга /Завхан, Улиастай сум/	2015	2017	1,200.0	1,259.3	59.3	4.9
7	IX.4.1.1	ХНХС	Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээний барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2016	2017	1,400.0	1,700.0	300.0	21.4
8	XI.1.13	БХБС	Сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургуулийн барилга, 960 суудал /Дорноговь, Замын-Үүд сум/	2013	2017	3,578.3	4,122.7	544.4	15.2
9	XI.1.21	БХБС	Буянт-Ухаа орон сууцны хорооллын 20000 м ³ бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төсөл, барилга угсралтын ажил /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2015	2017	20,000.0	33,495.0	13,495.0	67.5
10	XI.1.32	БХБС	Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 г, д Ø 800-ийн гол шугамыг Ø 1000 мм голчтой болгон өргөтгөх зураг төсөл, барилга угсралтын ажил /1 дүгээр хорооллын урд талаас баруун 4 замын уулзвар хүртэл, Павильон 19-өөс 3/11 холбоос хүртэл 3.4 км/	2014	2020	15,640.0	24,949.0	9,309.0	59.5
11	XII.2.1.12	БСШУСС	Баруун Монголын уламжлалт соёлын төвийн барилга /Увс, Улаангом сум/	2012	2017	2,332.0	2,995.8	663.8	28.5
12	XVI.1.3	ЭМС	Аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2012	2017	12,450.9	16,473.7	4,022.8	32.3
13	XII.2.1.8	БСШУСС	Аймгийн хөгжимт драмын театрын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/	2012	2018	6,707.3	9,448.3	2,741.0	40.9
14	XII.1.1.7	БСШУСС	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 104 дүгээр сургууль/	2012	2017	3,101.5	3,840.0	738.5	23.8
15	XII.1.1.12	БСШУСС	Сургуулийн барилга, 320 суудал /Архангай, Төвшрүүлэх сум/	2012	2017	2,438.0	3,001.8	563.8	23.1
16	XII.1.1.15	БСШУСС	Сургуулийн барилга, 960 суудал /Баянхонгор, Баянхонгор сум/	2012	2018	4,693.5	5,654.3	960.8	20.5
17	XII.1.1.20	БСШУСС	Сургуулийн барилга, 640 суудал /Булган, Булган сум/	2012	2018	2,663.7	4,186.4	1,522.7	57.2



алт 1-ийн үргэлжлэл

18	ХП.1.1.36	БСПУСС	Сургуулийн хичээлийн байрын барилга /Дархан-Уул, Дархан сум, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа сургууль/	2013	2017	3,006.9	3,241.9	235.0	7.8
19	ХП.1.1.41	БСПУСС	Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 84 дүгээр сургууль/	2015	2017	1,300.0	3,881.8	2,581.8	198.6
20	ХП.1.1.42	БСПУСС	Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Биндэр сум/	2009	2017	1,830.0	2,630.7	800.7	43.8
21	ХП.1.1.43	БСПУСС	Цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 8 дугаар хороо/	2015	2017	950.0	1,068.0	118.0	12.4
22	ХП.1.1.44	БСПУСС	Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Хөвсгөл, Цагааннуур сум/	2013	2017	1,502.5	1,900.7	398.2	26.5
23	ХП.1.1.45	БСПУСС	Сургуулийн барилга, 220 суудал /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/	2014	2017	1,591.1	2,023.5	432.4	27.2
24	ХП.1.1.59	БСПУСС	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо/	2012	2017	1,100.0	1,390.0	290.0	26.4
25	ХП.1.1.50	БСПУСС	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Булган, Булган сум, 1 дүгээр цэцэрлэг/	2012	2017	1,040.0	1,340.2	300.2	28.9
26	ХП.1.1.53	БСПУСС	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Өвөрхангай, Хужирт сум/	2015	2018	850.0	1,123.1	273.1	32.1
27	ХП.1.1.57	БСПУСС	Дотуур байрын барилга, 150 ор /Хөвсгөл, Ханх сум/	2012	2017	1,061.0	1,412.0	351.0	33.1
28	ХП.1.1.65	БСПУСС	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Завхан, Улиастай сум, 3 дугаар сургууль/	2012	2017	1,806.0	2,407.5	601.5	33.3
29	ХП.1.1.66	БСПУСС	Сургуулийн дотуур байрын барилга /Дундговь, Сайхан-Овоо сум/	2012	2017	650.0	1,371.7	721.7	111.0
30	ХП.2.1.9	БСПУСС	Соёлын төвийн барилга, 240 суудал /Хөвсгөл, Төмөрбулаг сум/	2012	2017	1,200.0	1,631.0	431.0	35.9
31	ХП.2.1.12	БСПУСС	Баруун Монголын уламжлалт соёлын төвийн барилга /Увс, Улаангом сум/	2012	2017	2,332.0	2,995.8	663.8	28.5
32	ХП.4.1.8	БСПУСС	Хүүхэд, залуучуудын соёл, үйлчилгээний цогцолбор, усан бассейн байгуулах /Архангай, Эрдэнэбулган сум/	2013	2017	1,500.0	1,762.1	262.1	17.5
33	ХҮ.1.4	ЭМС	Эрүүл мэндийн төвийн барилга /Хөвсгөл, Бүрэнтогтох сум/	2014	2017	1,315.8	1,557.0	241.2	18.3
34	ХҮ.1.5	ЭМС	Төрөх эмнэлэг, 50 ор /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2011	2017	2,898.9	4,294.0	1,395.1	48.1
35	ХҮ.1.9	ЭМС	Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 20 ор /Хөвсгөл, Их-Уул сум/	2014	2017	850.0	1,248.6	398.6	46.9
36	ХҮ.1.15	ЭМС	Төрөх эмнэлэг, 50 ор /Дорноговь, Сайншанд сум/	2011	2018	1,817.9	3,524.4	1,706.5	93.9
37	ХҮ.1.17	ЭМС	Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Говь-Алтай, Цээл сум/	2010	2017	535.0	1,013.4	478.4	89.4
38	ХҮ.1.18	ЭМС	Эрүүл мэндийн төвийн барилга /Дундговь, Дэлгэрхангай сум/	2012	2017	500.0	1,099.5	599.5	119.9
39	ХҮ.1.37	ЭХС	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Дарханы дулааны цахилгаан станцын техникийн шинэчлэлийн Монголын талын хөрөнгө /Дархан-Уул, Дархан сум/	2015	2017	7,000.0	10,600.0	3,600.0	51.4
НИЙТ ДҮН						132,628.3	195,199.5	62,571.2	47.2

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2017 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН
ХЭРЭГЖЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА

/сая төгрөг/

№	Хуулийн дугаар	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Хэрэгжээгүй шалтгаан			
				Эхлэх	Дуусах			ХАА зохион байгуулагдаагүй	ХАА хүчингүй болсон	Гүйцэтгэгч ажлаа хийгээгүй	Бусад
1	IX.1.1.2	ХНХС	Монгол-Солонгосын политехник коллежийн гадна шугам сүлжээний ажлын үлдэгдэл /Улаанбаатар, Хан-Уул/	2015	2017	1,400.0	45.7				1
2	IX.3.3.1	ХНХС	Япон улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн тоног төхөөрөмж	2017	2017	288.0	288.0	1			
3	XI.1.14	БХБС	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Өндөрхангай, Зүүнхангай, Тэс, Бөхмөрөн, Хяргас, Ховд, Малчин, Завхан, Баруунтуруун, Цагаанхайрхан сум/	2014	2017	2,000.0	60.0			1	
4	XI.1.18	БХБС	Тосгоны нэгдсэн халаалтын системийн барилгын ажил /Булган, Хангал сум, Хялганат тосгон/	2012	2017	634.3	63.7			1	
5	XI.1.19	БХБС	Цэвэр, бохир усны итгэмжлэгдсэн болон зөөврийн лаборатори байгуулах /орон нутагт/	2013	2018	948.8	100.0				1
6	XI.1.27	БХБС	Орон сууцны 14 дүгээр хорооллын цахилгааны 110/35/10 кВ-ын дэд станцын гаргалгаа 4 иж бүрдэл, 10 кВ-ын хаалттай хуваарилах байгууламж 3 иж бүрдэл, 10 кВ-ын хаалттай дэд өртөө 12 иж бүрдэл, 10 кВ-ын 18.4 км кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2018	7,137.0	3,051.5			1	
7	XI.1.28	БХБС	Орон сууцны 14 дүгээр хорооллын ус, дулаан дамжуулах төв 4 ширхэг, Ø 80/350 мм-ийн 1992 метр шугамын зураг төсөв, барилга угсралтын ажил	2014	2017	3,480.3	1,599.6			1	
8	XI.1.29	БХБС	Орон сууцны 14 дүгээр хорооллын бохир усны Ø 200/350 мм-ийн 1897 метр шугамын зураг төсөв, барилга угсралтын ажил, цэвэр усны Ø 200-350 мм-ийн 1166 метр шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2017	778.7	390.9			1	
9	XI.1.31	БХБС	Яармаг орон сууцны хорооллын цахилгаан хангамжид зориулан 10 кВ-ын түгээх сүлжээнд ойролцоо тооцоогоор 14.3 МВт чадлын хэрэглээг хангах 10 кВ-ын хуваарилах байгууламж 3 иж бүрдэл, 2х400 кВА чадалтай ТП 36 иж бүрдэл, 37.6 км урт 10 кВ-ын кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2017	8,746.2	209.9			1	
10	XI.1.36	БХБС	Дулааны Ø 65/200 мм-ийн голчтой 924 метр шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2017	754.0	527.8			1	
11	XI.1.37	БХБС	Усан хангамжийн Ø 32/150 мм-ийн 871 метр шугам, ариутгах татуургын Ø 300 мм-ийн 1246 метр шугамын угсралтын ажил	2014	2017	858.0	587.8			1	
12	XII.1.3.2	БСПУСС	Сайн дурын байгууллагуудын хандиваар баригдсан сургуулиудын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 30,31 дүгээр хороо/	2017	2017	120.0	120.0	1			
13	XII.2.1.10	БСПУСС	Соёлын төвийн барилга /Өмнөговь, Номгон сум/	2012	2017	1,176.0	288.0			1	
14	XII.4.1.3	БСПУСС	Спорт цогцолборын барилга, 700 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2014	2018	6,378.0	205.9			1	
15	XII.4.1.10	БСПУСС	Спорт цогцолборын барилга /Дорноговь, Хатанбулаг сум/	2012	2017	913.4	46.6			1	
16	XIII.1.1.1	ЗТХС	Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжих "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам" төслийн Өлгий-Ховд чиглэлийн авто замын үргэлжлэл хатуу хучилттай авто зам 189.7 км /аймаг дундын/	2014	2018	15,000.0	500.0		1		
17	XIII.1.1.2	ЗТХС	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам" төслийн 103.3 км хатуу хучилттай авто зам /Ховд/	2012	2018	31,460.0	361.3		1		
18	XIII.1.1.3	ЗТХС	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих "Баруун бүсийн авто замыг хөгжүүлэх" төсөл, Манхан-Ховдын 85.3 км, Өлгий-Хашаатын даваа 60 км авто зам /аймаг дундын/	2010	2018	12,959.2	132.0				1



алт 2-ын үргэлжлэл

19	XIII.1.1.4	ЗТХС	Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжих Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төслийн Сайншанд-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай замаас Өргөн сум хүртэлх 18.25 км хатуу хучилттай авто зам /Дорноговь/	2007	2017	2,301.2	415.9			1	
20	XIII.1.1.22	ЗТХС	ФМ-104.5 радиогийн хажуугийн 250 метр замыг асфальтан зам болгох, сансрын колонкийн арын төв зам хүртэлх /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2016	2017	500.0	250.0				1
21	XIII.1.1.41	ЗТХС	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто зам 27 км	2013	2017	14,310.0	55.9			1	
22	XIII.1.1.43	ЗТХС	Увс аймгийн төвийн авто замын барилгын ажил /Увс, Улаангом сум/	2014	2017	27,400.5	203.1				1
23	XIII.1.1.44	ЗТХС	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто замын барилгын ажил 50 км	2013	2017	6,789.6	129.6				1
24	XIII.2.1.1.2	ЗТХС	Нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан /Завхан, Улиастай сум/	2008	2017	8,651.5	344.9			1	
25	XV.1.3	ХХААХҮС	Хүнс, барааны худалдааны төвийн барилга /Хөвсгөл, Мөрөн сум/	2012	2017	4,200.0	558.2			1	
26	XV.1.4	ХХААХҮС	Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2012	2018	926.3	276.3			1	
27	XVI.1.21	ЭМС	"Хан-Уул дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Олимп хотхоны авто зам, авто зогсоол, гадна тохижилт" ажлын дутуу санхүүжилт /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2010	2017	57.1	57.1			1	
28	XVII.1.6	ЭХС	Төв аймгийн шинэ суурьшлын бүсийн хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулах	2014	2017	3,940.0	334.6				1
29	XVII.1.13	ЭХС	Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кВ-ын шугамын өргөтгөл, шинэчлэлт /улсын хэмжээнд/	2014	2017	17,000.0	1,109.7				1
30	XVII.1.16	ЭХС	Ирээдүй цогцолбор хорооллын дулааны 4100 метр гол шугам, 6 ширхэг дулаан дамжуулах төвийн зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2017	9,267.0	727.6			1	
31	XVII.1.17	ЭХС	Яармагийн гүүр орчмын хорооллын 110/35/10 кВ-ын 2х25 МВа чадалтай компьютерийн хяналт, удирдлагын системтэй дэд станцын барилга угсралтын ажил, 110 кВ-ын АС-240/39 дамжуулагч утастай, 2х2 мм шилэн кабель бүхий аянгын тросстой цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2014	2017	7,291.0	5.7				1
32	XVII.1.18	ЭХС	Сонгинохайрхан дүүргийн 5, 6 дугаар хороо, Ханын материал орчмын гэр хорооллын дулааны 2 Ø 300/400 мм-ийн голчтой 1.1 км шугам, 1 ширхэг ус, дулаан дамжуулах төв, Ø 150 мм-ийн голчтой 137 метр шугам, бие даасан 9.3 Гкал чадалтай дулааны эхүүсвэр, гадна төв бохир усны Ø 500 мм-ийн 1235 метр шугам, бохир усны Ø 200-300 мм-ийн 1788 метр шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2014	2017	9,854.0	987.3				1
33	XVII.1.21	ЭХС	110 кВ-ын Баянгол дэд станцаас 110 кВ-ын Радио телевиз дэд станц хүртэлх 110 кВ-ын 24 км, 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг, барилга угсралтын ажил /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2014	2017	814.9	394.1			1	
34	XVII.1.22	ЭХС	220 кВ-ын Сонгино дэд станцаас 110 кВ-ын Зайсан дэд станц хүртэлх 110 кВ-ын 50 км, 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг, барилга угсралтын ажил	2014	2017	2,139.7	583.9				1
35	XVII.1.24	ЭХС	Сонгино 220/110/35 кВ-ын 2х125 МВа дэд станц, 220 кВ-ын 10 км цахилгаан дамжуулах агаарын шугам /Улаанбаатар/	2014	2017	4,698.0	1,182.7				1
36	XVII.1.28	ЭХС	Холбооны 2 яндантай 2100 метр сувагчлалын зураг төсөл, барилга угсралтын ажил	2015	2017	252.0	59.0				1
37	XVII.1.29	ЭХС	Амгалан дулааны станцын ахуйн хэрэгцээний цэвэр усан хангамжийн угсралтын ажил /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2014	2017	228.0	9.9				1
Нийт дүн						215,652.7	16,264.2	2	2	19	14

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2017 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН
ХЭРЭГЖИЛТ ДУТУУ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА

/сая төгрөг/

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Санхүүжүүлсэн дүн		Ажлын гүйцэтгэл		Хэрэгжилт дутуу шалтгаан					
			Эхлэх	Дуусах			Нийт ажил эхэлснээс хойш	Үүнээс, 2017 онд	Нийт мөнгөн дүнгээр	Үүнээс, 2017 онд	Гүйцэтгэлийн үйл ажиллагаанаас	Санхүүжилт хугацаандаа олгогдоогүйгээс	Зураг, төсөвт өөрчлөлт орж дахин магадлал хийгээж хугацаа алдсан	Гадна иккнөрийн дэд бүтэц шийдвэрлэгдээс	Гэрээний хугацаа	Хэрэгжих боломжгүйгээс
1	III.1.1.5	Аврах гал унтраах ангийн барилга /Төв, Зуунмод сум/	2013	2017	2,700.0	1,096.8	2,649.9	1,041.7	2,711.6	1,096.8		1				
2	VII.1.1.2	Монгол Улсын хэмжээнд 2014-2017 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын бэлтгэл ажил, зураг төсөл, хөрөнгө оруулалт	2014	2017	27,056.7	381.2		33.0		33.0						1
3	XI.1.10	Бүгд Найрамдах Чех Улсын хөрөнгө оруулалтаар эргэн төлөгдөх нөхцөлөөр хэрэгжих "Евро Эко төгөл" төсөл /Орхон/	2013	2017	8,926.2	780.0	6,537.5	780.0	6,537.5	780.0		1				
4	XI.1.16	Шинээр барилгын материалын лаборатори байгуулах /Өмнөговь/	2013	2017	999.0	353.2	999.0	296.9	942.7	296.9	1					
5	XI.1.25	"Ирээдүй цогцолбор" хорооллын 2 дугаар эзлэгийн бохир усны Ø 150-450 мм-ийн голчтой 2200 метр гол шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2017	388.8	287.3	365.0	280.7	365.0	280.7					1	
6	XI.1.45	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид 2 дугаар тунгаагуур 2 ширхэг, биоцөөрөм барих /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2013	2017	8,519.1	137.0	7,560.1	137.0	7,580.1	137.0		1				
7	XI.1.57	Цэвэр усны Ø 32/150 мм-ийн голчтой 1400 метр шугамын барилга угсралтын ажил	2014	2017	182.0	76.1	105.9	36.5	105.9	36.5		1				
8	XII.1.1.1	Япон Улсын Засгийн газрын тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа сургуулийн барилгын өргөтгөл төслийн монголын талын хөрөнгө /улсын хэмжээнд/	2006	2017	6,300.0	721.6	565.2	565.2	565.2	565.2	1					
9	XII.1.1.22	Сургуулийн барилгын комплекс, 320 суудал /Хөвсгөл, Улаан-Уул сум/	2012	2018	3,238.0	725.7	1,366.2	329.5	1,366.2	329.5	1					
10	XII.1.1.31	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 11 дүгээр хороо, 126 дугаар сургууль/	2011	2017	3,266.8	677.7	2,928.9	339.7	2,928.9	339.7	1					
11	XII.1.1.45	Сургуулийн барилга, 220 суудал /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/	2014	2017	2,023.5	433.4	1,224.0	232.3	1,224.0	232.3	1					
12	XII.1.1.51	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Баянхонгор, Шинэжинст сум/	2013	2017	611.0	134.8	599.5	131.6	599.5	131.6	1					
13	XII.1.1.59	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо/	2012	2017	1,390.0	441.2	990.2	441.2	1,061.3	239.3	1					
14	XII.1.1.60	Цэцэрлэгийн барилга, 100 ор, /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2012	2017	656.7	482.7	656.7	475.6	565.8	384.7	1					
15	XII.1.1.63	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас олгосон буцалтгүй тусламжийн монголын талын хөрөнгө /1 цэцэрлэг, 21 сургууль/	2016	2017	1,000.0	800.0	402.1	402.1	402.1	402.1	1					
16	XII.1.1.71	Сургуулийн барилга, спорт заал худалдаж авах, 160 суудал /Завхан, Баянхайрхан сум/	2016	2017	2,600.0	1,600.0	1,600.0	1,600.0	1,600.0	1,600.0		1				
17	XII.2.1.7	Ханхэнтий чуулгын барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2011	2017	8,353.7	1,906.7	4,011.0	1,743.9	3,332.4	1,065.3						1
18	XII.2.1.16	Хархирлагийн соёл түүхийн төвийн барилга /Дорнод, Баян-Уул сум/	2012	2017	243.9	164.0	237.7	160.8	218.8	138.8						1
19	XII.3.1.2	Биологийн идэвхитэй бэлдмэлийн үйлдвэрлэл, туршилтын цех /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2012	2017	2,252.9	210.7	2,157.8	210.7	2,042.2	95.1						1
20	XII.3.1.3	Шинжлэх ухааны судалгааны лаборатори, спортын танхим бүхий цогцолборын барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2012	2017	4,000.0	885.1	3,989.2	877.7	3,577.2	461.5						1
21	XII.4.1.5	Спорт цогцолборын барилга /Завхан, Улиастай сум/	2012	2017	7,400.0	1,500.0	7,117.8	1,301.8	7,117.8	1,301.8						1
22	XII.4.1.8	Хүүхэд, залуучуудын соёл, үйлчилгээний цогцолбор, усан бассейн байгуулах /Архангай, Эрдэнэбулган сум/	2013	2017	1,762.1	262.1	1,524.6	220.0	1,566.5	54.4						1
23	XIII.1.1.5	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих "Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх" төсөл /Дорноговь, Замын-Үүд сум/	2011	2017	16,335.0	3,125.1	3,125.1	3,125.1	3,125.1	3,125.1		1				
24	XIII.1.1.21	Дарь-Эх цогцолборын авто замын ажил /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 21 дүгээр хороо/	2016	2017	650.0	450.0	294.5	294.5	294.5	294.5			1			
25	XIII.1.1.32	Ховдын Булган-Үенч-Ховд чиглэлийн авто замын барилга 60 км	2014	2017	18,173.6	5,362.3	17,581.6	4,107.2	17,643.3		1					
26	XIII.4.6	Баянзүрх дүүрэг, Дандарбаатарын гудамжнаас баруун тийш Офицеруудын ордны араар явуулж ШУТИС-ийн Холбоо мэдээллийн сургуулийн урд замтай холбох авто зам, Хилчний гудамжийг үргэлжлүүлэн Б.Доржийн гудамжтай холбох авто зам, 13 дугаар хороолол, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамжийг хороолол дундуур Нарны замтай холбох авто замын зураг төсөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2014	2017	75.4	26.0	48.7	25.6	48.7	25.6					1	
27	XIII.4.7	Төмөр замын 5 дугаар цэцэрлэгийн баруун талаар Нарны замын туслах болон хорооллын доторх замыг холбосон авто зам, Хөрмөс төвийн зүүн талын замаас зүүн тийш Баянгол дүүргийн баруун талын замтай холбох зам, 6 дугаар Бичил хорооллын урд зам, 40 дүгээр сургуулийн баруун талаар Ард-Аюуш өргөн чөлөө хүртэл /хуучнаар Москва ресторан/ холбосон зам, Москва рестораны өмнө Ард Аюушийн гудамжнаас Дилав хутагт Жамсранжавын гудамж хүртэлх авто замын зураг төсөл /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2014	2017	49.9	22.2	37.2	21.9	37.2	21.9					1	
28	XVI.1.5	Төрөх эмнэлэг, 50 ор /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2011	2017	4,294.0	1,695.4	4,271.9	1,673.3	4,271.9	1,673.3	1					
29	XVI.1.22	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Булган, Хутаг-Өндөр сум/	2012	2017	1,214.0	31.6	1,180.4	31.6	1,180.4	31.6		1				
30	XVI.1.23	Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа "Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах" төслийн монголын талын хөрөнгө /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2014	2020	20,000.0	2,400.0	4,164.7	2,164.7	4,164.7	2,164.7	1					



алт 3-ын үргэлжлэл

31	XVII.1.1	Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах ажлын үргэлжлэл / улсын хэмжээнд/	2014	2017	22,291.8	13,291.8	10,903.8	10,934.0	10,964.5	10,964.5					1
32	XVII.1.8	12 а магистралийн ТК-1211 цэгээс урагш гарсан 2 Ø 400 мм-ийн голчтой шугамыг 2 Ø 500 мм болгон өргөтгөх, 3х500х70 хүчин чадалтай шинээр даралт өргөх насос станц барих, зургийн хамт /Улаанбаатар/	2015	2017	7,296.0	1,597.3	5,801.3	102.6	5,801.3	102.6	1				
33	XVII.1.12	Баруун-Урт-Асгат-Эрдэнэцагааны 35 кВ-ын 197 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, 110/35/6 кВ-ын дэд станцын өргөтгөл /Сүхбаатар/	2014	2017	8,400.0	1,289.7	7,979.3	869.3	7,979.3	869.3	1				
34	XVII.1.15	Амгалан дулааны станц 348 МВт-ын туршилт, тохируулгын ажил /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2015	2017	3,988.3	1,010.6	228.3	228.3	228.3	228.3	1				
35	XVII.1.20	220 кВ-ын Улаанбаатар дэд станцаас 14 дүгээр хорооллын дэд станц хүртэлх 110 кВ-ын 9.7 км 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил	2014	2017	938.4	311.9	1,427.0	100.0	1,427.0	100.0	1				
36	XVII.1.32	Нийслэлийн гэр хорооллын цахилгаан шугам сүлжээ, дэд станцыг өргөтгөж хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгө буюу 20,000 айл өрхийг 4.0 кВт чадалтай цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэх ажил	2017	2017	39,500.0	39,500.0	35,718.6	35,719.6	18,858.1	18,858.1	1				
37	XVII.1.34	Зарим аймгийн төвийн дулааны станцын 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангах	2017	2017	3,547.5	3,547.5	1,045.3	1,045.4	1,045.3	1,045.3	1				
38	XVII.1.37	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжих Дарханы дулааны цахилгаан станцын техникийн шинэчлэлийн монголын талын хөрөнгө /Дархан-Уул, Дархан сум/	2015	2017	10,600.0	3,450.0	8,327.2	3,450.0	8,327.2	3,450.0	1				
Дүн					251,224.3	91,168.7	149,723.1	75,531.0	131,807.3	52,957.0	18	8	1	3	

Хавсралт 4

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2017 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДИТ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛЭЭС ИЛҮҮ САНХҮҮЖИЛТ АВСАН АЖ АХУЙН НЭГЖИЙН СУДАЛГАА

/төгрөг/

№	ТЕЗ	Барилга, байгууламжийн нэр	Гүйцэтгэгчийн нэр	Төсөл, арга хэмжээний байршил	Илүү олгосон санхүүжилтийн дүн
1	БСШУСС	Спорт цогцолборын барилга	Бүрд констракшн ХХК	Улаанбаатар, Налайх дүүрэг	245,828,380.00
2	БСШУСС	Соёлын өвийн төвийн барилга	Заг ХХК	Улаанбаатар, Хан-Уул дүүрэг	908,000,000.00
3	БСШУСС	Ханхэнтий чуулгын барилга	Макс майнд ХХК	Хэнтий аймаг, Мөрөн сум	890,302,758.00
4	БСШУСС	104 дүгээр сургуулийн барилга, 640 суудалтай	Фужи Алтай ХХК	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг	28,632,539.00
5	ХЗДХС	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн барилга	Шинэ барилга ХХК	Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг	4,963,231.00
6	ЭМС	Төрөх эмнэлэг, 50 ортой	Лайт капитал хаус ХХК	Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум	849,626,752.00
7	ЭМС	Дорноговь 50 ортой эмнэлэг	Монинжбар ХХК	Дорноговь аймаг Сайншанд сум	600,690,842.00
8	БСШУСС	Хөгжимт драмын театр	Акми холдинг ХХК	Архангай аймаг, Эрдэнэбулган сум	402,369,834.00
9	БХС	Цэргийн нэгдсэн эмнэлгийн цогцолбор	Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ	Улаанбаатар, Баянзүрх дүүрэг	91,277,635.00
10	ЗГХЭГД	Аймгийн Засаг даргын Тамгын газрын барилга	Түмэн Алт ХХК	Булган аймгийн Булган сум	48,315,034.00
11	БСШУСС	Үндэсний номын сан	Акми холдинг ХХК	Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг	8,737,200.00
12	БХС	Говийн бүсийн сургалтын төв	Изо хаус ХХК	Өмнөговь, Даланзадгад сум	235,782,047.00
13			Солид констракшн ХХК	Өмнөговь, Даланзадгад сум	354,609,336.00
		ДҮН			4.669.135.588.00



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2017 ОНЫ САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ

/сая төгрөг, хувь/

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	Хуулийн нэмэлт, өөрчлөлт (2017.10.26-нд батлагдсан)			Санхүүжсэн	Тендерийн хэмнэлт	Үүнээс				Бодит гүйцэтгэл	Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн хувь		
		ТАХ- ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн			Зориулалт бусаар зарцуулсан	Аудитын дүнгээр суутгагдсан	ТАХ- ний тоо	Мөнгөн дүн		Сангийн ям	ҮАГ	Зөрүү
1	АТГ	1	1,031.4	851.4	851.4	-	-				851.4	100.0	100.0	-
2	БХС	4	49,979.4	4,896.9	4,896.8	0.1	-				4,896.9	100.0	100.0	-
3	ГХС	2	5,978.2	1,518.2	1,518.2	-	-				1,518.2	100.0	100.0	-
4	УЕП	1	952.7	88.3	88.3		-				88.3	100.0	100.0	-
5	ХЗДХС	9	74,833.1	33,337.3	33,306.2	31.1	-				33,337.3	99.9	100.0	(0.1)
6	УУХҮС	1	2,848.2	2,848.2	2,833.9	14.3	-				2,848.2	99.5	100.0	(0.5)
7	МУШС	10	45,243.4	7,055.1	6,985.7	14.3	230.9				6,769.1	99.0	95.9	3.1
8	МУИХД	1	1,688.0	1,688.0	1,661.9	26.1	-				1,688.0	98.5	100.0	(1.5)
9	ЭМС	29	194,679.1	61,740.8	60,823.2	387.8	-		2	1,773.0	59,438.0	98.5	96.3	2.2
10	ХНХС	11	25,720.7	7,810.8	7,464.7	12.4	-		1	242.0	7,235.1	95.6	92.6	3.0
11	Сангийн сайд	6	46,377.8	8,639.7	8,222.6	69.0	-				8,291.6	95.2	96.0	(0.8)
12	БСШУСС	106	420,646.9	104,310.2	98,210.0	1,892.8	-		27	4,011.1	96,091.7	94.2	92.1	2.1
13	МУЕС	1	8,100.0	2,778.0	2,582.5	195.5	-				2,778.0	93.0	100.0	(7.0)
14	БХБС	66	477,699.2	73,811.5	66,096.7	1,123.6	-		24	5,488.5	61,731.8	89.5	83.6	5.9
15	ЗТХС	73	802,377.7	143,915.5	127,135.7	1,208.3	-				128,344.0	88.3	89.2	(0.9)
16	БОАЖС	3	2,593.5	824.3	714.2	69.7	2.7				781.2	86.6	94.8	(8.2)
17	ХХААХҮС	5	52,066.3	26,984.6	22,364.8	2,000.3	730.0				23,635.1	82.9	87.6	(4.7)
18	ЭХС	38	273,284.4	113,245.0	89,320.7	8,010.5	-		1	14,131.7	83,199.5	78.9	73.5	5.4
19	ЗГХЭГД	6	17,253.7	5,763.3	4,508.0	11.8	-				4,519.8	78.2	78.4	(0.2)
20	Концессын эргэн төлөлт	15	354,428.1	177,741.6	176,153.7	-	-	172.2			175,981.5	99.1	99.0	0.1
21	ДҮН	388	2,857,781.8	779,848.7	715,739.2	15,067.6	963.6	172.2	55	25,646.3	704,024.7	91.8	90.3	1.5

ТЭМДЭГЛЭЛ